

БАТЛАВ

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

Л.НАСАНЦЭНГЭЛ

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ХАРЬЯА
СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ**

**ХОГ ХАЯГДАЛ ЗАЙЛУУЛАХ, ХОРТОН МЭРЭГЧИЙН УСТГАЛ,
АРИУУТГАЛЫН БАРАА, ХАЛДВАРГҮЙТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Төслийн нэр:

**СЭМҮТ-ийн эмнэлгийн болон ахуйн хог хаягдал зайлцуулах
устгах үйлчилгээ, хортон мэрэгчдийн устгах үйлчилгээ,
арийутгалын бараа, халдвартгүйтэлийн үйлчилгээ худалдан
авах**

Төслийн дугаар:

СЭМҮТ-ТЕ-2019/07-02

Тендер шалгаруулалт
гэрээний нэр:

**Эмнэлгийн болон ахуйн хог хаягдал зайлцуулах устгах
үйлчилгээ, хортон мэрэгчдийн устгах үйлчилгээ,
арийутгалын бараа, халдвартгүйтэлийн үйлчилгээ худалдан
авах**

Тендер шалгаруулалт
гэрээний дугаар:

СЭМҮТ-ТЕ-2019/07-02

**2019 он
Улаанбаатар хот**

БҮЛЭГ I. ТЕНДЕРИЙН УРИЛГА ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: Урилга нийтлэгдэх:

2019-04-04

Төслийн нэр, дугаар:

СЭМҮТ-ТЕ-2019/07-02

1. **Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв** нь эрх бүхий тендерт оролцогчдыг
Багц-4 Ариутгал халдвартай тээлийн бараа худалдан авах - 628,126 төгрөгийн тендерийн баталгаа байршиулах
тухай битүүмжлэл бүхий тендер ирүүлэхийг урьж байна.
2. Унийн санал авах жишиг баримт бичгийг Худалдан авах ажиллагааны цахим хаягаар /tender.gov.mn/ авна уу. Эргэн төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэл нь 50.000 /тавин мянган төгрөг/ байна. Төлбөрийг цахим хэлбэрээр шилжүүлнэ.
3. Тендер шалгаруулалтанд тавигдах шаардлага:
 - a. **Хийж гүйцэтгэсэн үйлчилгээний орлого** – 2018 онуудын орлогын дундаж хэмжээ нь оролцогчийн санал болгож буй үнийн дүнгийн 25%-аас багагүй байх;
 - b. **Түргэн хөрвөх чадвартай мөнгөн хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ** - Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө, авах боломжтой зээлийн нийт хэмжээ нь тендерт санал болгож буй үнийн дүнгийн 10%-аас доошгүй байх;
 - c. **Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо** - 2018 онуудын аудитлагдсан санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийн хамт;
 - d. **Сүүлийн 3 жил хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг** - 2018 оны ижил төстэй хэрэгжүүлсэн ажил нь оролцогчийн санал болгож буй тендерийн үнийн дүнгийн 20%-аас багагүй байх;
 - e. **Тусгай зөвшөөрөл шаардах эсэх** – Тийм
4. Гадаадын этгээдийг оролцуулахгүй.
5. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба **628,126₮ [Зургаан зуун хорин найман мянга нэг зуун хорин зургаан төгрөг]** төгрөг бүхий тендерийн баталгаатай хамт ирүүлнэ. Тендерийг **2019 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 12 цаг 00 минутаас** өмнө **ЦАХИМ ХЭЛБЭРЭЭР /tender.gov.mn/** болон **ЭХ ХУВИЙГ ЦААСАН** хэлбэрээр **/Баянзүрх дүүрэг, 9 дүгээр хороо, 50 дугаар гудамж,** Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Удирдлагын байр, **213 тоот өрөө, Хүний нөөцийн мэргэжилтэн Ш.Сугармаа холбогдох утас: 70150526, 99843212/-аар** ирүүлэх бөгөөд тендерийг нээхээр заасан хугацаанд уг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан нийтийн өмнө **2019 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 12 цаг 30 минутаас** нээнэ.

БҮЛЭГ II. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

Тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны тухай тайлбар

Энэ бүлэг захиалгчийн шаардлагад нийцсэн тендер бэлтгэхэд тендерт оролцогчдод шаардлагатай мэдээллийг өгдөг. Түүнчлэн тендер хүлээн авах, нээх, үнэлэх болон гэрээ байгуулах эрх олгох үйл ажиллагаатай холбогдсон мэдээллийг энд тусгана.

Үйлчилгээ үзүүлэгч этгээдийн ажлын гүйцэтгэлийг удирдах, гэрээний төлбөр хийх зэрэгтэй холбоотой асуудлууд, болон гэрээний хүрээнд талуудын хүлээх эрх, үүрэг, эрсдэлийн талаар энэ бүлэгт оруулахгүй, харин Бүлэг IV-т буюу Гэрээний ерөнхий нөхцөл болон Бүлэг V гэрээний тусгай нөхцөл гэсэн хэсгүүдэд тус тус заана.

Тендерт оролцогчдод өгөх зааварчилгаа нь гэрээний хэсэг болохгүй ба гэрээнд гарын үсэг зурагдах хүртэл мөрдөгдөнө.

Тендерт оролцогчдод өгөх зааварчилгаа

А. Ерөнхий зүйл

1. Тендерийн цар хүрээ
 - 1.1 Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтэнд (цаашид ТШӨХ гэх) дурдагсан **Захиалагч** нь Гэрээний хавсралт А-д тодорхойлсон **үйлчилгээг** үзүүлэх этгээдийг сонгохоор тендер шалгаруулж байна. **ТШӨХ**-д гэрээний нэр болон дугаарыг заасан болно.
 - 1.2 Шалгарсан тендерт оролцогч нь **ТШӨХ**-д заасан хугацаанд үйлчилгээг гүйцэтгэж дуусгах үүрэг хүлээнэ.
2. Хөрөнгийн эх үүсвэр
3. Эрх бүхий тендерт оролцогч
 - 2.1 Захиалагч дээр дурдсан үйлчилгээг **ТШӨХ**-д тодорхойлсон эх үүсвэрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
 - 3.1 Тендерийн урилга нь эрх бүхий тендерт оролцогч бүрт нээлттэй. “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 9.3 дахь хэсэгт заасныг үндэслэн гадаадын этгээдийг тендерт оролцуулахгүй байхаар шийдвэрлэж тендерийн урилгад зааснаас бусад тохиолдолд тендерт оролцогч болон тендерт оролцогч түншлэлийн гишүүн бүр нь аль ч улсын харьялалтай байж болно.
 - 3.2 Дараах тохиолдолд тендерт оролцогч (түншлэлийн гишүүн бүрт нэгэн адил хамаарна)-ийг эрх бүхий бус гэж үзнэ. Үүнд:
 - 3.2.1 Төлбөрийн чадваргүй болсон, татан буугдаж байгаа, дампуурлаас зайлсхийх зорилгоор зээлдүүлэгчтэй тохиролцсон, бизнесийн үйл ажиллагааг нь зогсоосон, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу дээр дурдсантай адилтгах нөхцөлд байгаа;
 - 3.2.2 Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө төлөөгүй;
 - 3.2.3 Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь захиалагчаас хараат байдлаар үйл ажиллагаа явуулдаг;
 - 3.2.4 Сүүлийн 2 жилийн хугацаанд худалдан авах ажиллагаанд оролцохдоо гэрээний үүргээ ноцтой зөрчсөн, биелүүлээгүй, эсхүл мэргэжлийн үйл ажиллагаанд алдаа гаргасныг шүүх, эрх бүхий байгууллага тогтоосон;
 - 3.2.5 Тендерт оролцогч нь бараа, ажил, үйлчилгээний зураг төсөл, техникийн тодорхойлолт болон бусад баримт бичгийг бэлтгэсэн, эсхүл гэрээний хэрэгжилтийг хянах, зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр нэр нь дэвшигдсэн этгээдтэй нэгдмэл сонирхолтой;
 - 3.2.6 Илт худал мэдээлэл бүхий тендер ирүүлснийг эрх бүхий байгууллага тогтоосон;
 - 3.2.7 Сүүлийн 2 жилийн хугацаанд Авиалгын эсрэг хууль, Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль болон Эрүүгийн хуульд заасан авилгын, залилан мэхлэх, зохиомол тохиролцоо хийх, айлан сүрдүүлэх үйлдлийн аль нэгэнд холбогдсон болохыг шүүх тогтоосон;

- 3.2.8 Тендерт оролцогч нь (туслан гүйцэтгэгч бүрийг оролцуулан) уг төслийн зураг төсөл, техникийн тодорхойлолт болон бусад баримт бичгийг бэлтгэсэн, эсхүл гэрээг хянах зөвлөхөд нэр нь дэвшигдсэн этгээдтэй нэгдмэл сонирхолтой бол;
- 3.2.9 Энэхүү тендер шалгаруулалтад хоёр буюу түүнээс дээш тооны тендерт оролцогчийн хууль ёсны төлөөлөгч нь нэг этгээд бол;
- 3.2.10 Энэхүү тендерийн баримт бичгийн 14 дүгээр зүйлд хувилбарт тендер ирүүлэхийг зөвшөөрснөөс бусад тохиолдолд тухайн тендер шалгаруулалтад аливаа тендерт оролцогч нэгээс дээш тендер ирүүлсэн бол; (Гэвч энэхүү заалт нь аливаа этгээдийг нэгээс дээш тендерт туслан гүйцэтгэгчээр оролцохыг, эсхүл нэг тендер шалгаруулалтад нэгээс олон багцад тендер ирүүлэхийг хязгаарлахгүй)
- 3.2.11 Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд бүтэц зохион байгуулалт болон санхүүгийн хувьд захиалагчаас хараат байдлаар үйл ажиллагаа явуулдаг бол; /Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуульд зааснаар төр ашгийн төлөө үйл ажиллагааг зөвхөн төрийн өмчит үйлдвэрийн газар болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээр дамжуулан явуулахаар заасан тул эдгээрээс бусад төрийн байгууллага, албан газар тендерт оролцох эрхгүй/
- 3.3 Тендерт оролцогч 3.2.1 - 3.2.11-д дурдсан нөхцөл үүссэн эсэх тухай мэдэгдлийг захиалагчид бичгээр гаргаж өгөх үүрэгтэй. Эдгээр нөхцөл үүссэн эсэхийг магадлах зорилгоор захиалагчаас тавьсан шаардлагын дагуу тендерт оролцогч холбогдох баримт, нотолгоог захиалагчид ирүүлнэ.
- 4. Тендерт оролцогчийн чадвар**
- 4.1 Тендерт оролцогч нь Бүлэг III-т заасан Тендерийн маягт болон чадварын мэдээллийн маягтыг бөглөж, хийх ажлын аргачлалын талаарх урьдчилсан тайлбар, ажлын хуваарь, шаардлагатай бол холбогдох график зургийн хамтаар ирүүлнэ.
- 4.2 **ТШӨХ-д** өөрөөр заагаагүй бол тендерт оролцогч дараах мэдээлэл болон баримт бичгийг тендерийн хамт Бүлэг III-т заасан маягтаар ирүүлнэ. Үүнд:
- (а) Хууль эрх зүйн статус, бүртгүүлсэн газар, бизнесийн үйл ажиллагааны чиглэл, буюу үүсгэн байгуулагдсаныг тодорхойлох албан ёсны баримт бичгийн эхээс хийсэн хуулбар, тендерт оролцогчийн өмнө үүрэг хүлээж түүнийг төлөөлж тендерт гарын үсэг зурах этгээдийн албан ёсны итгэмжлэл;
 - (б) **ТШӨХ-д** тодорхойлсон хугацаанд хийж гүйцэтгэсэн үйлчилгээний нийт мөнгөн дүнг жил бүрээр гаргаж ирүүлэх;
 - (в) **ТШӨХ-д** тодорхойлсон хугацаанд тухайн үйлчилгээтэй шинж чанар болон хэмжээгээрээ ижил төстэй үйлчилгээг гэрээний үндсэн дээр хийж гүйцэтгэсэн болон одоо хийж байгаа тухайг захиалагч болон түүнтэй холбоо барьж

- болов нэр, хаяг, төрөл хэмжээ зэрэг гэрээний дэлгэрэнгүй мэдээллийн хамт жил тус бүрээр гаргаж ирүүлэх;
- (г) Тухайн гэрээг хийж гүйцэтгэхэд шаардлагатай гол тоног төхөөрөмжүүдийн жагсаалтыг гаргаж ирүүлэх;
- (д) Гэрээг хэрэгжүүлэхэд санал болгож буй удирдах болон техникийн голлох боловсон хүчний чадвар, туршлагын талаарх мэдээлэл;
- (е) Тухайн тендерт оролцогчийн санхүүгийн байдлыг харуулах аудитаар баталгаажсан **ТШӨХ-д** тодорхойлсон жилийн санхүүгийн тайлан, баланс;
- (ё) Тухайн гэрээг хэрэгжүүлэхэд ажлын капитал хүрэлцээтэйг нотлох баримт (зээл авах боломж болон бусад боломжтой санхүүгийн эх үүсвэрүүд);
- (ж) Захиалагч тухайн тендерт оролцогчийн харилцагч банкнаас түүний талаар тодорхойлолт хүсэхэд татгалзахгүй тухай зөвшөөрсөн албан бичиг;
- (з) **ТШӨХ-д** тодорхойлсон жилд тухайн тендерт оролцогчтой холбоотой гарсан аливаа зарга маргааны талаарх мэдээлэл, маргааны тоо;
- (и) Үйлчилгээг гүйцэтгэхэд тухайн гэрээний 10 хувиас дээш өртөг бүхий ажлыг туслан гүйцэтгүүлэхээр болсон саналыг;
- 4.3 Хоёр ба түүнээс дээш тооны хуулийн этгээд хамтран ажиллах гэрээний үндсэн дээр нэг тендерт оролцогч /цаашид талуудыг хамтад нь “түншлэл” гэх, тус бүрийг нь “түншлэлийн гишүүн” гэх/ болж тендер ирүүлэх тохиолдолд **ТШӨХ-д** өөрөөр заагаагүй бол дараах шаардлагыг хангасан байна:
- (а) түншлэлийн бүх гишүүдийн хувьд тендер хүчин төгөлдөр байхаар тендерт гарын үсэг зурсан байх;
- (б) ТОӨЗ-ны 1.1-д заасан үйлчилгээ үзүүлэх гэрээг хэрэгжүүлэхэд бүх гишүүн хамтран болон тус тусдаа хүлээх хариуцлагыг тодорхойлж хамтран ажиллах гэрээнд тусгасан байх;
- (в) түншлэлийн аль нэг болон бүх гишүүний нэрийн өмнөөс үүрэг хүлээх, зааварчилгаа хүлээн авахад тэдгээрийг төлөөлөх эрх бүхий нэг гишүүн томилох;
- (г) нийт гэрээний гүйцэтгэл, түүний дотор төлбөр тооцоог зөвхөн төлөөлөх эрх бүхий гишүүнтэй харилцаж, гүйцэтгэх тухайг хамтран ажиллах гэрээгээр зохицуулсан байх;
- (д) түншлэлийн гэрээний хувийг тендерийн хамт ирүүлэх;
- 4.4 Тендерт оролцогч гэрээ байгуулах эрх олж авахын тулд дор дурдсан чадварын доод шалгуурыг хангасан байна.
- (а) Жилийн турш гүйцэтгэсэн Үйлчилгээний тоо хэмжээ нь **ТШӨХ-д** заасан дүнгээс багагүй байх;
- (б) **ТШӨХ-д** тодорхойлсон хугацаанд тухайн гэрээтэй төрөл, нарийн төвөгтэй байдлаараа дүйцэхүйц ижил 2-оос доошгүй үйлчилгээ үзүүлэх гэрээний ерөнхий гүйцэтгэгчээр ажилласан туршлагатай байх; (дурдсан ажлын доод тал нь 70 хувь нь хэрэгжсэн байх нөхцөлд энэ шаардлагыг хангасан гэж үзнэ)

		(в) ТШӨХ-д жагсаалтаар заасан зайлшгүй байх үндсэн тоног төхөөрөмжүүдийг цаг хугацаанд нь бэлэн байлгах тухай санал (өөрийн эзэмшилийн, түрээслэх, хөлслөх, г.м);
		(г) Гэрээнд заасан үйлчилгээтэй төрөл, дүнгээрээ дүйцэхүйц үйлчилгээний 5-аас доошгүй жил, түүний дотор 3-аас доошгүй жилд нь гэрээг хариуцаж ажилласан туршлага бүхий менежертэй байх;
		(д) Бусад гэрээт ажилд ашиглах буюу ашиглаж буй хөрөнгө болон энэ гэрээний дагуу хийгдэж болох урьдчилгаа төлбөрийг оролцуулахгүйгээр түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээл нь ТШӨХ-д дурдсан дүнгээс багагүй байх;
		Тухайн тендерт оролцогч эсхүл түншлэлийн аль нэгэн гишүүний эсрэг гарсан аливаа зарга маргааны шийдвэр болон арбитрын шийдвэр нь түүнийг чадварын шаардлага хангаагүй гэж үзэх үндэслэл болно.
4.5	Тендерт оролцогч 4.4 (а), (б) болон (д)-д заасан чадварын доод шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг тодорхойлохын тулд түншлэлийн гишүүн тус бүрийн үзүүлэлтийг хооронд нь нэмж тооцно. Гэхдээ гишүүн тус бүр 4.4 (а), (б) болон (д)-д заасан чадварын доод шалгуур үзүүлэлтийн доод тал нь 25 хувийг, төлөөлөх эрх бүхий гишүүн доод тал нь 40 хувийг хангасан байна. Энэ шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд түншлэлийн тендерээс татгалзана. ТШӨХ-д өөрөөр заагаагүй тохиолдолд тендерт оролцогч чадварын доод шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг тодорхойлоход түүний туслан гүйцэтгэгчийн ажлын туршлага, санхүүгийн нөөц бололцоог харгалzan үзэхгүй.	
5. Тендерт оролцогч нэг этгээд нэг тендер ирүүлэх	5.1	Нэг тендерт оролцогч дангаараа, эсхүл түншлэлийн гишүүн болж тендер шалгаруулалтад оролцож байгаа бол зөвхөн нэг тендер ирүүлнэ. Тендерт оролцогч болон түншлэлийн гишүүд нэгээс дээш тендер ирүүлсэн, эсхүл ирүүлэхэд оролцсон бол түүний ирүүлсэн бүх тендерээс татгалзана. Энэ нөхцөл нь туслан гүйцэтгэгчийн хувьд болон хувилбарт тендер ирүүлэхийг зөвшөөрсөн тохиолдолд тус тус хамаарахгүй..
6. Тендер шалгаруулалтад оролцох зардал	6.1	Тендерт оролцогч нь түүний тендерийг бэлтгэх болон ирүүлэхтэй холбогдон гарах бүх зардлыг өөрөө хариуцах бөгөөд ямар ч нөхцөлд эдгээр зардалтай холбогдох үүрэг хариуцлагыг захиалагч хүлээхгүй.
7. Ажлын талбайтай танилцах	7.1	Шаардлагатай үйлчилгээг үзүүлэх байршил, талбай болон түүний орчин тойрны нөхцөл байдалтай газар дээр нь танилцаж судлан тендер бэлтгэх, гэрээ байгуулахад шаардлагатай байж болох бүх мэдээллийг тендерт оролцогч олж авч ашиглаж болно. Ажлын талбайтай газар дээр нь очиж танилцах зардлыг тендерт оролцогч өөрөө хариуцна.
		Б. Тендерийн баримт бичиг
8. Тендерийн баримт бичгийн агуулга	8.1	Тендерийн баримт бичгүүдийн бүрдэлд доорх жагсаалтад дурдсан баримт бичгүүд болон 10 дугаар зүйлийн дагуу гаргасан нэмэлт өөрчлөлтүүд багтана. Бүлэг II Тендерт оролцогчдод өгөх зааварчилгаа; III Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт;

- IV Тендерийн маягт болон чадварын мэдээллийн
маягт;
- V Гэрээний ерөнхий нөхцөл;
- VI Гэрээний тусгай нөхцөл;
- VII Үйлчилгээний гүйцэтгэлийн тодорхойлолт
болон зургууд; (хэрэв байгаа бол)
- VIII Үйл ажиллагааны хуваарь;
- IX Баталгааны маягт;
- 8.2 Тендерт оролцогч нь тендерийн баримт бичиг дахь бүх зааварчилгаа, маягууд, нөхцөлүүд болон тодорхойлолтуудыг шалгаж нягтласан байвал зохино. Тендерийн баримт бичигт ирүүлэхийг шаардсан бүх мэдээллийг дутуу ирүүлэх, эсхүл тендерийн баримт бичгийг томоохон зөрүүгүй хангаж чадаагүй тендер ирүүлэх нь тендерт оролцогчийн эрсдэлд хамаарах ба энэ нь түүний тендерээс татгалзах үндэслэл болж болно. Бүлэг IV, VIII болон IX –т холбогдох мэдээллүүдийг бөглөж **ТШӨХ**-д заасан тоо хэмжээгээр хувилж олшруулан тендерийн хамт ирүүлнэ.
- 9. Тендерийн баримт бичгийн тодруулга**
- 9.1 Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах бол энэ тухай хүсэлтээ бичгээр, эсхүл утсан холбоогоор (утсан холбоо гэж зөвхөн телекс болон факсыг ойлгоно) тендерийн урилгад заасан захиалагчийн хаягаар мэдэгдэнэ. Захиалагч тендер ирүүлэх эцсийн хугацаанаас **14 хоногийн өмнө** ирүүлсэн тодруулга авах тухай аливаа хүсэлтэд хариу өгнө. Хүсэлтийн агуулга, түүнд өгөх захиалагчийн хариуг хүсэлтийн эх сурвалжийг дурдалгүйгээр тендерийн баримт бичиг худалдаж авсан тендерт оролцогч бүрт хүргүүлнэ.
- 10. Тендерийн баримт бичгийн нэмэлт өөрчлөлт**
- 10.1 Захиалагч, тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас өмнө нэмэлт хийх замаар тендерийн баримт бичигт өөрчлөлт оруулж болно.
- 10.2 Ийнхүү хийсэн аливаа нэмэлт өөрчлөлт нь тендерийн баримт бичгийн салшгүй хэсэг болох бөгөөд түүнийг захиалагчаас тендерийн баримт бичиг худалдан авсан тендерт оролцогч бүрт бичгээр, эсхүл утсан холбоогоор хугацаа алдалгүй мэдэгдэнэ. Тендерт оролцогч нэмэлт өөрчлөлт тус бүрийг хүлээн авсан тухайгаа захиалагчид утсан холбоогоор мэдэгдэх үүрэгтэй.
- 10.3 Тендерийн баримт бичигт орсон нэмэлт өөрчлөлтийг тендерт тусгахад нь хангалттай хугацааг тендерт оролцогчид олгох шаардлагатай гэж захиалагч үзвэл тендер хүлээн авах эцсийн хугацааг 20.2-т заасны дагуу сунгана.

С. Тендер бэлтгэх

- 1. Тендерийн хэл** 11.1 Тендер, түүнчлэн тендертэй холбоотойгоор захиалагч тендерт оролцогчийн хооронд харилцаж буй албан бичиг, захидалтууд болон бусад баримт материалыг тендерт оролцогчид өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэх ба холбогдох бүх баримт бичиг нь монгол хэл дээр, гадаадын этгээд худалдан авах ажиллагаанд оролцох эрхтэй бол тэдгээр нь ТШӨХ-д заасан хэл дээр байна. ТББ-ийн монгол хэл дээрх хувь гадаад хэл дээрхтэй зөрчилдвэл монгол хэл дээр бэлтгэсэн ТББ-ийн заалтыг баримтална.
- 11.2 Аливаа тендерийг дагалдах баримт бичиг, хэвлэмэл материал нь өөр хэл дээр байж болох бөгөөд энэ тохиолдолд тэдгээрийн тендерт холбогдох хэсгийг ТОӨЗ-ны 11.1-д заасан хэл рүү хөрвүүлсэн орчуулгыг тендерт оролцогч давхар бэлтгэж ирүүлэх бөгөөд уг орчуулгыг тендерийг хянан үзэх, үнэлэхэд харгалзана.
- 12. Тендерийн бүрдэл** иж 12.1 Тендерт оролцогчийн ирүүлэх тендер нь дараах зүйлсээс бүрдэнэ:
- (а) Тендерийн маягт (Бүлэг III-т заасан маягтын дагуу);
 - (б) Тендерийн баталгаа;
 - (в) Үнэлэгдсэн үйл ажиллагааны хуваарь;
 - (г) Чадварын мэдээлэл (Бүлэг III-т заасан маягтын дагуу) болон бусад баримт бичиг;
 - (д) Зөвшөөрөгдсөн бол хувилбарт тендер болон **ТШӨХ-д** тодорхойлж шаардсан тендерт оролцогчийн бүрдүүлж ирүүлэх бусад материалын бүрдэлээр хамаарууд;
- 12.2 “Тендерийн урилга”-д заасан бол тендерт оролцогч нь нэг буюу нэгээс олон багцад оролцоо тендер ирүүлж болох бөгөөд энэ тохиолдолд нэгээс илүү багцад гэрээ байгуулах эрх авах бол аливаа үнийн хөнгөлөлт үзүүлэх тухай саналаа хамт ирүүлж болно.
- 13. Тендерийн үнэ** 13.1 Гэрээ нь гэрээний хавсралт-А болон дөрөвдүгээр бүлэгт заасан үйлчилгээний үр дүнгийн тодорхойлолтод тодорхойлсон үйлчилгээг хамрах ба тендерт оролцогчийн ирүүлсэн үнэлэгдсэн үйл ажиллагааны хуваарыт үндэслэнэ.
- 13.2 Тендерт оролцогч нь дөрөвдүгээр бүлэгт заасан үйлчилгээний үр дүнгийн тодорхойлолт /буюу ажлын даалгавар/-д тодорхойлж VIII бүлэгт заасан үйл ажиллагааны хуваарыт жагсаасан үйлчилгээний бүх нэр төрлийг үнэлж, түүнийгээ маягтад бөглөж ирүүлнэ. Тендерт оролцогчийн үнийг нь тусгаж ирүүлээгүй үйлчилгээний аливаа нэр төрлийг хийж гүйцэтгэсний зардлыг захиалагч санхүүжүүлэхгүй бөгөөд үүнийг үйл ажиллагааны хуваарыт тусгагдсан бусад нэр төрлийн үйлчилгээний үнэлгээ, үнэд шингэсэн гэж үзнэ.
- 13.3 Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас **28 хоногийн** өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр үйлчилгээ үзүүлэгч этгээдийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.

13.4 Хэрэв **ТШӨХ-д** тухайлан зөвшөөрсөн бол тендерт оролцогчийн ирүүлсэн үнийг гэрээний хэрэгжилтийн явцад гэрээний өрөнхий болон тусгай нөхцөлийн 6.6 дахь зүйлд заасан үнэ тохируулах нөхцөлийн дагуу тохируулна. Тендерт оролцогч гэрээний өрөнхий болон тусгай нөхцөлийн дагуу шаардагдах бүх мэдээллийг тендертэй хамт ирүүлнэ.

13.5 Нэмэлт үйлчилгээ үзүүлсэн тохиолдолд нөхөн төлбөр хийх хэмжээг тодорхойлох зорилгоор тухайн тендерт оролцогч гэрээний Г болон Д хавсралтад заасан маягтын дагуу нийт үнийн задаргааг ирүүлнэ.

14. Тендериийн болон төлбөрийн валют

14.1 Тендерт оролцогч үйлчилгээний нийт үнийг дараах валютуудаар тус тусд нь тооцож ирүүлнэ:

(а) Үйлчилгээнд шаардагдах орцуудыг тендерт оролцогч захиалагчийн улсаас нийлүүлнэ гэж үзэж байгаа бөгөөд **ТШӨХ-д** өөрөөр заагаагүй бол тэдгээрийн үнийг төгрөгөөр тооцож ирүүлнэ.

(б) Үйлчилгээнд шаардагдах орцуудыг тендерт оролцогч нь гаднаас нийлүүлнэ гэж үзэж байгаа бол тэдгээрийн үнийг 3 – аас дээшгүй улсын валютаар тооцож ирүүлж болно.

14.2 **ТШӨХ-д** тодорхойлсон эрх бүхий этгээдийн тендер хүлээн авах эцсийн хугацаанаас **28 хоногийн** өмнөх өдрийн албан ханшыг баримтлан тендерт оролцогч дээрх 14.1 –т заасан үнэлгээгээ төгрөгт хөрвүүлж тооцно.

14.2 Тендерт оролцогч нь шаардлагатай гадаад валютын талаар өөрийн тендер тодорхой тусгаж ирүүлнэ.

14.3 Захиалагч тендерт оролцогчоос гадаад валютын шаардлагаа нотлох буюу нийт дүнгээр илэрхийлсэн хэмжээ болон гэрээний тусгай нөхцөлд тусгасан хэмжээ нь бодитой, 14.1 нөхцөлийн шаардлагыг хангаж байгаа гэдгээ харуулахыг шаардаж болно.

15. Тендер хүчинтэй байх хугацаа

15.1 Тендер нь **ТШӨХ-д** заасан хугацаанд хүчинтэй байна.

15.2 Онцгой нөхцөл байдал үүсч тендер хүчинтэй байх хугацааг сунгахаар шийдвэрлэсэн тохиолдолд, захиалагч бүх оролцогчдод хандаж өөрсдийн тендер хүчинтэй байх хугацааг сунгах талаар хүсэлт гаргана. Энэхүү хүсэлт болон түүнд өгөх тендерт оролцогчийн хариу нь бичгээр, эсхүл утсан холбоогоор хийгдэнэ. Тендерт оролцогч тендерийн баталгаагаа үл гүйцэтгүүлэн өөрийн тендер хүчинтэй байх хугацааг сунгахаас татгалзах эрхтэй. Дээрх хүсэлтийг зөвшөөрсөн тендерт оролцогч тендерийн баталгааны хүчинтэй хугацааг 16 дугаар зүйлд нийцүүлэн мөн хугацаагаар сунгана. Ингэхдээ уг тендерийн агуулгыг өөрчлөхийг хориглоно.

15.3 Тогтмол үнийн (үнийн тохируулга хийхийг зөвшөөрөөгүй тохиолдолд) гэрээний хувьд тендер хүчинтэй байх хугацааг 60-аас дээш хоногоор сунгасан тохиолдолд шалгарсан тендерт оролцогчийн төлбөрт тооцох гадаад болон дотоод валютын үнийн дүнг тендер хүчинтэй байх анхны хугацаа дууссанаас хойш 60 дахь хоногоос эхлэн гэрээ байгуулах эрх олгох хүртэл хугацаанд **ТШӨХ**, эсхүл тендер хүчинтэй байх хугацааг сунгахыг хүссэн хүсэлтэд заасан итгэлцүүрийг

ашиглан нэмэгдүүлнэ. Тендерийн үнэлгээг энэ залруулгыг үл харгалзсан тендерийн үндэслэн явуулна.

16. Тендерийн баталгаа

- 16.1 ТШӨХ-д шаардсан тохиолдолд тендерт оролцогч нь мөн ТШӨХ-д заасан үнийн дүнтэй тэнцэх тендерийн баталгааг ирүүлнэ.
- 16.2 Тендерт оролцогч нь **ТШӨХ-д** тодорхойлсон үнийн дүн бүхий төгрөгөөр, эсхүл бусад чөлөөтэй хөрвөх валютаар гаргасан тендерийн баталгааг тендерийн хамт ирүүлнэ.
- 16.3 Тендерийн баталгаа нь Монгол Улсын, эсхүл гадаадын нэр хүндтэй банкны гаргасан баталгаа, Засгийн газрын бонд эсхүл Засгийн газраас хүлээн зөвшөөрсөн үнэт цаасны хэлбэрээр байж болно. Тендерийн баталгааг 4 дүгээр бүлэг дэх тендерийн баталгааны маягтаар, эсхүл тендер хүлээн авахаас өмнө захиалагч урьдчилан хүлээн зөвшөөрсөн маягтаар ирүүлнэ. Тендерийн баталгаа нь тендер хүчинтэй байх **хугацаанаас хойш 28 хоногийн хугацаанд** хүчинтэй байна.
- 16.4 Тендерийн баталгааны эх хувийг ирүүлнэ.
- 16.5 Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.
- 16.6 Энэ зүйлд шаардсаны дагуу хүлээн зөвшөөрөхүйц тендерийн баталгаа ирүүлээгүй аливаа тендерээс захиалагч үндсэн шаардлага хангаагүй гэж үзэж татгалзана.
- 16.7 Тендер нь шалгаргаагүй оролцогчийн тендерийн баталгааг 20.1-д заасан тендер хүчинтэй байх хугацаанаас хойш 28 хоногт багтаан хүчингүй болгоно.
- 16.8 Тендер нь шалгарсан оролцогчийн тендерийн баталгааг 33 дүгээр зүйлийн дагуу гэрээнд гарын үсэг зурж, 34 дүгээр зүйлийн дагуу гүйцэтгэлийн баталгааг ирүүлсэн тохиолдолд хүчингүй болгоно.
- 16.9 Тендерийн баталгааг дараах тохиолдолд гүйцэтгүүлнэ.
 - (а) Тендер нээсний дараа тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө тендерт оролцогч өөрийн тендерийг буцааж авсан, эсхүл буцааж авахыг бичгээр мэдэгдсэн;
 - (б) Тендерт оролцогч 27.2-ын дагуу тендерийн үндэд хийсэн залруулгыг хүлээн зөвшөөрөгүй;
 - (в) Тендер нь шалгарсан тендерт оролцогч заасан хугацаанд багтаан;
 - 1) 33 дүгээр зүйлийн дагуу гэрээнд гарын үсэг зураагүй;
 - 2) 34 дугаар зүйлийн дагуу гүйцэтгэлийн баталгааг ирүүлээгүй;

17. Хувилбарт тендер

- 17.1 ТШӨХ-д тусгайлан заагаагүй тохиолдолд хувилбарт тендер ирүүлэхийг хүлээн зөвшөөрөхгүй. Хэрэв зөвшөөрсөн бол 17.2 заалтыг дагаж мөрдөнө.
- 17.2 Хэрэв ТШӨХ-д зөвшөөрсөн бол тендерийн баримт бичгийн шаардлагас өөр хувилбартай техникийн санал гаргах хүсэлтэй тендерт оролцогч тендерийн баримт бичгийн шаардлага, түүний дотор ажлын зураг, техникийн тодорхойлолтод заасан техникийн үндсэн шийдэлд нийцсэн үндсэн тендер ирүүлэх ёстой. Тендерт оролцогч үндсэн тендер ирүүлэхийн зэрэгцээ хувилбарт тендерт бүрэн үнэлгээ

		хийхийн тулд захиалагчид шаардагдах бүх мэдээлэл, түүний дотор ажлын зургийн тооцоо, техникийн тодорхойлолт, үнийн задаргаа, төлөвлөж буй барилгын ажлын арга барил болон бусад холбогдох мэдээллийг ирүүлнэ. Зөвхөн техникийн үндсэн шаардлагыг хангасан, хамгийн сайн үнэлэгдсэн үндсэн тендер ирүүлсэн тендерт оролцогчийн хувилбарт тендерийг захиалагч авч үзнэ. Хувилбарт тендерийг үндсэн тендерээс тусд нь дугтуйд хийж битүүмжлэн “Хувилбарт тендер” гэж бичнэ.
17.3		Хэрэв үйлчилгээний тодорхой хэсгийг хувилбар бүхий техникийн шийдэлтэйгээр ирүүлэхийг ТШӨХ -д зөвшөөрсөн бол үүнийг үйлчилгээний үр дүнгийн тодорхойлолт /Ажлын тодорхойлолт/ болон Бүлэг VIII-д тусгасан байвал зохино. Энэ тохиолдолд дээрх хувилбарыг үнэлэх аргыг ТШӨХ -д мөн адил тусгана.
18. Тендер ирүүлэх хувь болон тендерт гарын үсэг зурах	18.1	Тендерт оролцогч энэхүү зааварчилгааны 12 дугаар зүйлд заасан иж бүрдэл бүхий тендерийн эх хувийг тендерийн маягтын хамт бэлтгэн хавтаслаж “ЭХ ХУВЬ” гэж бичнэ. Тендерт оролцогч үүнээс гадна ТШӨХ -д заасан тоо ширхэг бүхий тендерийн хуулбар хувийг бэлтгэн хавтаслаж “ХУУЛБАР ХУВЬ” гэж бичнэ. Эх хувь болон хуулбар хувиуд хоорондоо зөрчилдсөн тохиолдолд эх хувийг баримтлана.
	18.2	Тендерийн эх болон хуулбар хувиудыг хэвлэж (компьютер, бичгийн машин гэх мэт), эсхүл арилдаггүй бэхээр бичиж, тендерт оролцогчийг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж баталгаажуулна. Тендерт оролцогчийн боловсруулсан тендерийн агуулга, үнэтэй холбоотой бүх хуудсанд төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурна. Хэвлэмэл танилцуулга, тайлан болон бусад байгууллагын гаргасан албан ёсны мэдээлэл зэрэг баримт бичиг үүнд хамаarahгүй.
	18.3	Захиалагчийн гаргасан зааварчилгаатай нийцүүлэх, эсхүл тендерт оролцогч өөрийн алдааг зайлшгүй шаардлагаар засварлахаас бусад тохиолдолд тендерт ямар нэг засвар, нэмэлт бичилт хийхгүй ба засвар, нэмэлт бичилт хийсэн тохиолдолд дээрх эрх бүхий этгээд гарын үсэг зурна.
		В. Тендер ирүүлэх
19. Тендерийг битүүмжлэх, бичиглэл хийх	19.1	Тендерт оролцогч нь тендерийн эх хувь болон бусад хуулбар хувиудыг тус тусд нь дугтуйд хийж битүүмжлэн “ЭХ ХУВЬ”, “ХУУЛБАР ХУВЬ” гэж бичиглэл бүхий дугтуйд хийж битүүмжлэн тэдгээрийг дахин давхар нэг дугтуйнд (гаднах) хийж битүүмжлэн захиалагчид ирүүлнэ.
	19.2	Доторх ба гаднах дугтуйнууд дараах мэдээллийг багтаасан байна. Үүнд:
	(а)	ТШӨХ -д дурдсан хаягаар захиалагчид хаяглана;
	(б)	ТШӨХ -д болон гэрээний тусгай нөхцөлд заасан гэрээний нэр, бүртгэлийн дугаарыг тэмдэглэнэ;
	(в)	ТШӨХ -д заасан тендер нээх хугацаанаас өмнө тендерийг нээж болохгүй тухай анхааруулсан бичиглэл хийнэ.
	19.3	Тендерийг 21 дүгээр зүйлд заасан үндэслэлээр хугацаа хоцорсон гэж зарласан тохиолдолд нээлгүй буцаах боломж

- бүрдүүлэх зорилгоор 19.2-т заасан мэдээллээс гадна доторхи дугтуй дээр тендерт оролцогчийн нэр, хаягийг дурдана.
- 19.4 Хэрэв гаднах дугтуйг дээр заасан байдлаар битүүмжилж, бичиглэл хийгээгүй бол захиалагч уг тендер буруу хаягаар хүргэгдсэн, эсхүл тендер нээхээс өмнө задарсанд хариуцлага хүлээхгүй.
- 20. Тендер хүлээн авах эцсийн хугацаа**
- 20.1 Тендерийг **ТШӨХ-д** заасан хугацаанаас хоцроолгүйгээр дээр дурдсан захиалагчийн хаягаар хүргүүлнэ.
- 20.2 Захиалагч 10 дугаар зүйлийн дагуу тендерийн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулсны улмаас тендер хүлээн авах эцсийн хугацааг сунгасан тохиолдолд захиалагч болон тендерт оролцогчийн эрх, үүрэг сунгасан хугацааны туршид хэвээр үйлчилнэ.
- 21. Хугацаа хоцорсон тендер**
- 21.1 Захиалагч ТОӨЗ-ны 20 дугаар зүйлд тодорхойлсон тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш хүлээж авсан аливаа тендерийг “Хугацаа хоцорсон” гэж зарлан түүнээс татгалзаж нээлгүйгээр буцаана.
- 22. Тендерт нэмэлт өөрчлөлт хийх болон тендерийг буцааж авах**
- 22.1 Тендерт оролцогч 20 дугаар зүйлд заасан тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө бичгээр мэдэгдэл өгсний дагуу өөрийн тендерт нэмэлт өөрчлөлт хийх, эсхүл өөрийн тендерийг буцааж авах эрхтэй.
- 22.2 Тендерт оролцогч нь өөрийн тендерт нэмэлт өөрчлөлт хийх, эсхүл түүнийг буцааж авах талаарх мэдэгдлээ ТОӨЗ-ны 18 ба 19 дүгээр зүйлийн дагуу бэлтгэж, битүүмжилж, бичиглэл хийхийн хамт доторхи ба гаднах дугтуй дээр “НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ХИЙХ ТУХАЙ”, эсхүл “ТЕНДЕРИЙГ БУЦААЖ АВАХ ТУХАЙ” гэсэн аль тохиорох бичилтийг хийж ирүүлнэ.
- 22.3 Тендер ирүүлэх эцсийн хугацаа өнгөрснөөс хойш аливаа тендерт ямар нэгэн нэмэлт өөрчлөлт хийж болохгүй.
- 22.4 Тендер хүлээн авах эцсийн хугацаа болон **ТШӨХ-д** заасан тендер хүчинтэй байх хугацаа, эсхүл 15.2-ын дагуу сунгасан тендер хүчинтэй байх хугацааны хооронд тендерийг буцааж авах нь 16 дугаар зүйлийн дагуу тендерийн баталгааг гүйцэтгүүлэх үндэслэл болно.
- 22.5 Тендерт оролцогч нь үнийн хөнгөлөлтийг зөвхөн энэ зүйлийн дагуу ирүүлсэн нэмэлт өөрчлөлтөөр тендерийнхээ үнийг өөрчлөх, эсхүл үндсэн тендерт тусгаж ирүүлэх замаар санал болгож болно.
- Г. Тендерийн нээх, үнэлэх**
- 23. Тендерийг нээх**
- 23.1 Захиалагч нь тендер болон 22 дугаар зүйлийн дагуу уг тендерт хийгдсэн нэмэлт өөрчлөлтийг **ТШӨХ-д** заасан газар, цаг хугацаанд нээнэ. Нээх үед тендерт оролцогчийн төлөөлөгч байлцах эрхтэй ба байлцсан бол тендерийн нээлтийн маягтад гарын үсэг зурна.
- 23.2 Эхлээд “Тендерийг буцааж авах тухай” гэсэн бичиглэл бүхий дугтуйг нээж, зарлана. Энэ зааварчилгааны 22 дугаар зүйлийн дагуу тендерийг буцааж авах тухай мэдэгдэл ирүүлсэн үндсэн тендерийг нээхгүй.
- 23.3 Тендерийг нээх үед тендерт оролцогчийн нэр, тендерийн нийт үнэ болон хувилбарт тендер ирүүлэхийг зөвшөөрсөн

тохиолдолд түүний нийт үнэ, санал болгосон үнийн хөнгөлөлт, тендерийн баталгаа ирүүлсэн эсэх, оролцогч өөрийн тендерт нэмэлт өөрчлөлт хийсэн, эсхүл буцааж авсан эсэх болон захиалагч шаардлагатай гэж үзсэн бусад мэдээллийг зарлаж, тэмдэглэл үйлдэнэ. ТОӨЗ-ны 21 дүгээр зүйлд заасан хугацаа хоцорсон тендер болон 22 дугаар зүйлд заасны дагуу тендерээ буцааж авах тухай мэдэгдсэнээс бусад ямар ч тендерээс нээлтийн үед татгалзаж болохгүй. Тендер нээх үед зарлагдаагүй тендерийн үнэ, үнийн хөнгөлөлт болон хувилбарт тендерийг үнэлгээнд харгалзахгүй. Хугацаа хоцорсон болон буцааж авсан тендерүүдийг задлалгүйгээр тухайн тендерт оролцогчид буцааж өгнө.

- 23.4 Захиалагч тендерийн нээлтийн протокол, тэмдэглэл хөтлөх бөгөөд үүнд 23.3 –ийн дагуу нийтэд танилцуулсан бүх мэдээллийг багтаана.

- 24. Нууцлах**
- 24.1 Тендерийг хянан үзэх, тодруулах, үнэлэх, харьцуулах болон гэрээ байгуулах эрх олгох зөвлөмжтэй холбогдсон мэдээллийг тендерт оролцогч болон тухайн тендер шалгаруулалтын үйл ажиллагаатай албан ёсоор холбогдолгүй хүнд гэрээ байгуултал задруулахыг хориглоно. Тендерийг үнэлэх, гэрээ байгуулах эрх олгох шийдвэр гаргах явцад тендерт оролцогчоос захиалагчид нөлөө үзүүлэх аливаа оролдлого нь түүний тендерээс татгалзах үндэслэл болж болно.
- 24.2 Хэрэв гэрээ байгуулах эрх олгогдсоны дараа тендерт оролцогч түүний тендер шалгараагүй учир шалтгааныг магадлах /тодруулах/-ыг хүсвэл энэ тухай бичгээр тайлбар авах хүсэлтээ захиалагчид тавина. Тайлбар авах тухай хүсэлт тавьсан тендерт оролцогч нь хуулийн 49.4 дүгээр зүйлд заасны дагуу холбогдох баримт бичиг мэдээлэлтэй танилцаж болно.

- 25. Тендерийн тодруулга**
- 25.1 Тендерийг хянан үзэх, үнэлэх болон харьцуулахад зайлшгүй шаардлагатай тохиолдолд тендерт оролцогчоос түүний ирүүлсэн тендер, үүний дотор үйл ажиллагааны хуваарь дахь үнийн задаргааны талаар тодруулга ирүүлэхийг хүсч болно. Энэ хүсэлт болон түүний хариултыг бичгээр, эсхүл утсан холбоогоор хийнэ. Гэхдээ тендерийн үнэлгээний явцад ТОӨЗ-ны 27 дугаар зүйлийн дагуу захиалагчийн илрүүлсэн арифметик алдааг залруулахад шаардлагатайгаас бусад тохиолдолд тендерийн үнэ болон агуулгад ямар нэгэн өөрчлөлт хийхийг хүсэх, санал болгохыг зөвшөөрөхгүй
- 25.2 ТОӨЗ-ны 25.1-д зааснаас бусад тохиолдолд тендерт оролцогч тендерийг нээснээс гэрээ байгуулах эрх олгох хүртэлх хугацаанд өөрийн тендертэй холбоотой аливаа асуудлаар захиалагчтай холбоо тогтоож болохгүй. Хэрэв тендерт оролцогч Захиалагчийн мэдэгдэлд нэмэлт мэдээлэл өгөхийг хүсвэл түүнийг бичгээр ирүүлнэ.
- 25.3 Тендерт оролцогчоос түүний тендерийг үнэлэх болон гэрээ байгуулах эрх олгох захиалагчийн шийдвэрт нөлөөлөх аливаа оролдлого нь түүний тендерээс татгалзах үндэслэл болно.

- 26. Тендерийг хянан** 26.1. Захиалагч тендерийг нарийвчлан үнэлэхээс өмнө тендерт үзэх, шаардлагад нийцсэн эсэхийг тогтоох
- (а) ТОӨЗ-ны 3 дугаар зүйлд заасан эрх бүхий тендерт оролцогчийн талаарх шаардлагыг хангасан эсэх;
- (б) Гэрээг хэрэгжүүлэх чадвартай эсэх;
- (в) Тендерийн иж бүрдэл, тендерт зохих ёсоор гарын үсэг зурсан эсэх
- (г) Шаардлага хангасан тендерийн баталгааг ирүүлсэн эсэх;
- (д) Бүрэн тендер ирүүлсэн эсэх;
- (е) Тендерийн баримт бичгийн үндсэн шаардлагыг хангасан тендер ирүүлсэн эсэх зэргийн хянан үзнэ.
- 26.2. Тендерийн баримт бичгийн үндсэн шаардлагыг хангасан тендер гэдэг нь тендерийн баримт бичгийн бүх нөхцөл, болзол болон үйлчилгээний тодорхойлолтын шаардлагыг томоохон зөрүүгүй хангасан тендерийг хэлнэ. Энэ шаардлагыг биелүүлээгүй зөрүү нь дараах шинж чанартай бол түүнийг томоохон зөрүү гэж үзнэ:
- (а) Үйлчилгээний хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхээр бол;
- (б) Гэрээнд заасан захиалагчийн эрх, тендерт оролцогчийн үүрэгт тендерийн баримт бичигтэй үл нийцэх зарчмын хязгаарлалт оруулсан бол;
- (в) Эдгээрийг хүлээн зөвшөөрөх нь үндсэн шаардлагыг хангасан тендер ирүүлсэн бусад оролцогчийн өрсөлдөөнд шударга бус байдал үүсгэхээр бол;
- 26.3. Захиалагч ТОӨЗ-ны 26.1-д заасан шаардлагад нийцээгүй тендерээс татгалзах бөгөөд энэхүү шалтгааныг үүсгэж байгаа зөрүү болон тайлбарыг засварлан тендерийг шаардлагад нийцсэн болгож болохгүй.
- 27. Алдааг залруулах** 27.1. Захиалагч шаардлагад нийцсэн гэж тогтоосон тендерт арифметик алдаа бий эсэхийг магадлан шалгаж дараах байдлаар залруулна:
- (а) Тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
- (б) Үйлчилгээний үнийн хуваарьт заасан нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
- (в) Нэгж үнийг үйлчилгээний тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхийлэгдсэн тендерийн байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг

залруулна.

- 27.2. Дээрх аргачлалын дагуу захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөснөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзах бөгөөд 16.9 (б)-ийн дагуу тендерийн баталгааг гүйцэтгэнэ.

28. Тендерийг үнэлэх валют

- 28.1. Тендерт оролцогч тендерийн нийт үнийг тооцоходоо 14.2-т заасан ханшийг хэрэглэсэн тохиолдолд тендерийг 14.1-д заасны дагуу төгрөгөөр үнэлнэ. Тендерийн үнэ өөр валютуудаар илэрхийлэгдсэн тохиолдолд Захиалагч үнэлгээг хялбарчлах зорилгоор тендерийн баримт бичгийн 14.2-т урьдчилан заасан ханшаар төлбөр хийгдэх валютыг төгрөгт хөрвүүлнэ.

29. Тендерийг үнэлэх, харьцуулах

- 29.1. Захиалагч зөвхөн 26 дугаар зүйлийн дагуу шаардлагад нийцсэн гэж тогтоосон тендерийг үнэлж, харьцуулна.
- 29.2. Захиалагч гагцхүү үнэлэхдээ дараах байдлаар тендерийн үнэд залруулга хийж, тендерийн харьцуулах үнийг тогтооно:
- (а) 27 дугаар зүйлийн дагуу алдааг залруулах;
 - (б) Үйл ажиллагааны хуваарь дахь магадлашгүй зардлын дүнг хасч тооцох бөгөөд, харин захиалагч Үйлчилгээний үр дүнгийн тодорхойлолт /эсхүл Ажлын даалгавар/-т шаардсан тохиолдолд тендерт оролцогчийн санал болгосон ажил-өдрийн зардлыг хасахгүй;
 - (в) Тендерт оролцогчийн санал болгож буй хүлээн зөвшөөрөхүйц нэмэлт өөрчлөлт буюу үнийн хөнгөлөлт, эсхүл ТӨЗ-ны 17 дугаар зүйлд заасны дагуу ирүүлсэн хувилбарт саналыг тооцож залруулах;
 - (г) Тендерийн орхигдуулсан зүйл, **ТШӨХ-д** заасан харгалзах хүчин зүйл болон мөнгөөр үнэлж болох зөрүүг үнэлгээнд харгалзах зорилгоор залруулна.
- 29.3. Захиалагч нь аливаа өөрчлөлт, зөрүү болон хувилбарт тендерийг хүлээн зөвшөөрөх, эсхүл татгалзах эрхтэй. Тендерийн баримт бичгийн шаардлагыг давуулж биелүүлэх, эсхүл бусад замаар тендерийн баримт бичгийн шаардлагад заагаагүй үр ашгийг захиалагчид санал болгосон өөрчлөлт, зөрүү, хувилбарт тендер болон бусад хүчин зүйлсийг захиалагч тендерийн үнэлгээнд харгалзахгүй.

- 29.4. Тендерийн үнэлгээг хийхдээ гэрээний хэрэгжилтийн явцад гэрээний ерөнхий нөхцөлийн 6.6 дугаар зүйлийн дагуу хийгдэх аливаа үнийн тохируулгаас гарч болох үр дагаврын тооцоог харгалзахгүй.
- 29.5. Шаардлагад нийцсэн тендерүүдийг 29.2-т заасны дагуу үнэлгээ хийж тендер тус бүрийн харьцуулах үнийг тогтооно. Хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг хамгийн сайн үнэлэгдсэн тендер гэж тооцно.

**30. Дотоодын
тендерт
оролцогчийн
давуу эрх**

- 30.1. Дотоодын тендерт оролцогчдод аливаа давуу эрхийн зөрүү тооцохгүй.

Д. Гэрээ байгуулах эрх олгох

31. Гэрээ байгуулах 31.1. Захиалагч нь шаардлагад нийцсэн бөгөөд хамгийн сайн гэж үнэлэгдсэн санал ирүүлсэн тендерт оролцогчид ТОӨЗ-ны 32 дугаар зүйлийн дагуу гэрээ байгуулах эрх олгоно.

- 31.2. Хэрэв тухайн гэрээ нь 12.2 дугаар зүйлд заасан багцад хамаарах бол түүнтэй зэрэг гэрээ байгуулах эрх олгогдох бусад багцуутдтай хамтад авч үзэж үнэлсний үндсэн дээр хамгийн сайн үнэлэгдсэн тендерийг тодруулна.

32. Гэрээ байгуулах 32.1. **эрх олгох тухай**
мэдэгдэл,
гэрээнд гарын
үсэг зурах

- 32.1. Захиалагч нь гэрээ байгуулах эрх олгох шийдвэрийг тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө гаргаж шалгарсан оролцогчид бичгээр мэдэгдэл хүргүүлэх бөгөөд энэ талаар бусад тендерт оролцогчид нэгэн зэрэг бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх үйлчилгээнд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

- 32.2. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл нь гэрээ байгуулах үндэслэл болно.

- 32.3. Тендерийн баримт бичигт заасан гэрээний маягт, нөхцөл нь Захиалагч болон шалгарсан тендерт оролцогчийн хоорондын бүх тохиролцоог илэрхийлэх бөгөөд Захиалагч түүнийг гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийн хамт шалгарсан тендерт оролцогчид илгээнэ.

- 32.4. Шалгарсан тендерт оролцогч нь гэрээний маягтыг хүлээн авснаас хойш ажлын 5-аас дээш хоногийн дараа **ТШӨХ**-д тусгайлан заасан хугацаанд багтаан түүнд гарын үсэг зурж захиалагчид хүргүүлнэ.

- 32.5. Захиалагч засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим хуудас www.e-procurement.mn вэб сайтад тендерийн нэр болон багцын дугаарыг дараахь мэдээллийн хамтаар гэрээ байгуулах эрх олгосон даруй нийтэлнэ:
- 1) Тендер ирүүлсэн оролцогч бүрийн нэр;
 - 2) Тендерийн нээлтэнд зарлагдсан үнийн саналууд;
 - 3) Нарийвчлан үнэлэгдсэн тендерийн нэр, үнийн санал;
 - 4) Тендерээс нь татгалзсан оролцогчийн нэр, татгалзсан шалтгаан;
 - 5) Тендер нь шалгарсан оролцогчийн нэр, түүний санал болгосон тендерийн үнэ, гэрээний үнийн дүн.

32.6 Хэрэв гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл гарснаас хойш аливаа тендерт оролцогч түүний тендер шалгараагүй үндэслэлийг тодруулахыг хүсвэл энэ тухай хүсэлтээ захиалагчид бичгээр гаргана. Захиалагч энэ хүсэлтийн хариуг тухайн тендерт оролцогчид даруй өгнө.

33. Гүйцэтгэлийн баталгаа

- 33.1. Шалгарсан тендерт оролцогч **ТШӨХ-д** өөрөөр заагаагүй бол гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор **ТШӨХ-д** заасан дүнгээр, заасан маягт болон гэрээний нөхцөлийн дагуу гүйцэтгэлийн баталгааг захиалагчид ирүүлнэ.

33.2. Гүйцэтгэлийн баталгааг:

- (а) Тендерт оролцогчийн сонголтоор Монгол Улсад байрладаг банкаар буюу гадаадын банкны Монгол Улсад байрладаг харилцагч банкаар, эсхүл
- (б) Захиалагчийн хүлээн зөвшөөрсөн гадаадын банкаар,
- (в) Засгийн газрын бонд болон засгийн газраас хүлээн зөвшөөрсөн **ТШӨХ-д** тусгайлан заасан үнэт цаасны хэлбэрээр гаргуулж болно.

33.3. Шалгарсан тендерт оролцогч 33.1-д заасан шаардлагыг биелүүлээгүй нь гэрээ байгуулах эрхийг хүчингүй болгох болон тендерийн баталгааг гүйцэтгүүлэх хангалттай үндэслэл болно.

34. Урьдчилгаа төлбөр, баталгаа

- 34.1 Захиалагч **ТШӨХ-д** заасан хэмжээнээс хэтрэхгүй урьдчилгаа төлбөрийг гэрээний нөхцөлд заасны дагуу гаргаж өгнө.

БҮЛЭГ III. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ (ТШӨХ)

Энэ бүлгийн мэдээллийг захиалагч тендерийн баримт бичгийг бэлтгэхдээ заавал бөглөж оруулах хэрэгтэй.

Захиалагч тухайн үйлчилгээний цар хүрээ, хэмжээ, онцлог байдлыг харгалзан тендерт оролцогчийн ерөнхий, санхүүгийн болон техник, боловсон хүчний талаарх шалгуур үзүүлэлтийг нарийвчлан тогтоож ТШӨХ-д тусгана. Ингэхдээ үндэслэл муутайгаар хэт өндөр шалгуур эсхүл тодорхой этгээдийн чадварт тухайллан нийцүүлэх зорилгоор тогтоон сонирхсон этгээдийн өрсөлдөөнд оролцох боломжийг хязгаарлаж болохгүй гэдгийг анхаарах ёстой.

Энд оруулсан мэдээлэл нь тендерийн урилгад оруулсан мэдээлэлтэй зөрчилдөх ёсгүй.

Хаалтанд байгаа тоо нь тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны холбогдох зүйлийн дугаарыг заана.

- (1.1) Захиалагч гэж *Сэтгэцийн Эрүүл Мэндийн Үндэсний Төв нь БЗД-ийн 9 дүгээр хороо, 50 дугаар гудамжинд байрлана.*
Гэрээний нэр болон дугаар нь – *СЭМҮТ-ТЕ-2019/07-02 дугаартай тендер*
- (1.2) Дуусгахаар төлөвлөсөн хугацаа нь - **2020-05-31**
- (2.1) Зээлдэгч гэж: *Улсын төсвийн хөрөнгөөр 100% санхүүжигдэнэ.*
Төсөл гэдэг нь - Эмнэлгийн болон ахуйн хог хаягдал зайлцуулах устгах үйлчилгээ, хортон мэрэгчдийн устгах үйлчилгээ, ариутгалын бараа, халдвартгүйтэлийн үйлчилгээ худалдан авах нэр бүхий
Багц – 4 Ариутгал халдвартгүйтэлийн бараа худалдан авах багцууд бүхий төсөл
Зээлийн дугаар гэдэг нь **байхгүй**
- (4.2) ТББ-ын 4.2 дахь хэсэгт заасны дагуу тендерт оролцогчдоос шаардсан мэдээлэлийг дараах байдлаар өөрчлөнө.
Тендерт оролцогч дараах нэмэлт материалыг өөрийн тендерт хавсралтаар ирүүлнэ. Үүнд:
1) *Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар* - Нотариатаар баталгаажуулсан байх, хугацаа дуусаагүй байх;
2) *Харилцагч банкны мэдэгдэл* - Банкны тодорхойлолт, түүнчлэн 2018 онуудын ижил төстэй ажил гүйцэтгэсэн талаархи дансны хуулгыг хавсаргах;

- 3) Монгол Улсын хуулийн дагуу *татвар, хураамж, төлбөрөө* төлөөгүй, өр үүсээгүй болох нотолгоо болох харьяа татварын байгууллагын тодорхойлолт;
- 4) Химиин бодис хэрэглэх, худалдах зөвшөөрөлтэй байх;
- 5) Тендерт оролцогчийн өмнө үүрэг хүлээж түүнийг төлөөлж тендерт гарын үсэг зурах этгээдийн албан ёсны итгэмжлэл;

(4.2.6)

2018 онуудын хийж гүйцэтгэсэн үйлчилгээний орлогын дундаж хэмжээ нь оролцогчийн санал болгож буй унийн дүнгийн 25%-аас багагүй байх;

(4.2.в)

2018 оны ижил төстэй хэрэгжүүлсэн ажил нь оролцогчийн санал болгож буй тендерийн унийн дүнгийн 20%-аас багагүй байх; Ижил төстэй хэрэгжүүлсэн бараа, ажил үйлчилгээг гүйцэтгэсэн гэрээний хуулбарыг заавал хавсаргана.

Гэрээг гүйцэтгэхэд зайлшигүй шаардлагатай ундсэн гол тоног тохөөрөмж, гүйцэтгэх ажлын жагсаалт:

- 1) Гүйцэтгэгч нь эмнэлгийн болон ахуйн хог хаягдал тээвэрлэх зориулалтын тээврийн хэрэгсэлтэй байх;
- 2) Зориулалттай машин, техник хэрэгсэл, тээврийн хэрэгсэлийн гэрчилгээний хуулбарыг баталгаажуулсан байх;
- 3) Ачиж, буулгах, устгах зөөгч, ачигчтай, ажилтантай байх;
- 4) Үйлчилгээг хэрэгжүүлэх хангалттай ажиллах хүчний нөөцтэй болохыг нотлох *З-аас доошигүй ажилтны анкет* ажилтан тус бүрээр, мэргэжлийн болон боловсролын гэрчилгээний хуулбар, ажилтан тус бурийн нийгмийн даатгалын дэвтэрийн нүүр болон татвар төлөлтийн хуулбар, тухайн ажилтанг томилсон тэмдэглэлийн хуулбар, Нийгмийн даатгалын хэлтэсийн тодорхойлолт болон НД-8 маягтын дагуу 3 сарын маягт ирүүлэх/

2018 онуудын аудитлагдсан санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийн хамт ирүүлэх;

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө, авах боломжтой зээлийн нийт хэмжээ нь тендерт санал болгож буй унийн дүнгийн 10%-аас доошигүй байх;

Унийг дараах баримтаар нотлоно.

- 1) Бэлэн мөнгө буюу дансан дахь үлдэгдэл /харилцагч банкин дахь/
- 2) Арилжааны банкны хурлын шийдвэр гарсан зээлийн тодорхойлолт, холбогдох баримтын хамт.

Харилцагч банкнаас түүний талаар тодорхойлолт хүсэхэд татгалзахгүй тухай зөвшөөрсөн албан бичиг ирүүлэх;

- (4.2.3) Сүүлийн **2 жилийн** хугацаанд худалдан авах ажиллагаанд оролцохдоо гэрээний үүргээ ноцтой зөрчсөн, биелүүлээгүй, эсхүл мэргэжлийн үйл ажиллагаанд алдаа гаргасан эс гаргасан тухай **шүүх, эрх бүхий байгууллагын** тодорхойлолт
- (4.3) ТББ-ын 4.3 дахь хэсэгт шаардсаны дагуу тендерт оролцогчдоос шаардсан чадварын мэдээлэл буюу өгөгдлүүдийг дараах байдлаар өөрчлөнө: “**түшилэлийг зөвшөөрөхгүй**”;
- (8.2) болон** Бэлтгэж ирүүлэх тендерийн хуулбар хувь нь 1% хувь байх ба тендерт оролцогч нь тендерийн эх хувийг тусд нь дугтуйд хийж битүүмжлэн “**ЭХ ХУВЬ**” гэж бичиглэл бүхий дугтуйд хийж битүүмжлэн захиалагчид ирүүлнэ.
- (11.1)** Тендерийн хэл: **Монгол дээр ирүүлэх**;
- (12.1)** Тендерт оролцогчийн бусад нэмэлт баримт материал ирүүлэх шаардлагатай гэж захиалагч үзвэл түүний жагсаалтыг оруулна.
1) Тендерийн маяг бүлэг III –т заасан маягтын дагуу;
2) Тендерийн баталгаа;
3) Үнэлэгдсэн үйл ажиллагааны хуваарь;
4) Чадварын мэдээллийн бүлэг;
- (13.4)** Гэрээний нөхцөлийн 6.6 дахь хэсэгт заасан үнийн тохируулга нь энэ гэрээнд үнийн тохируулга “**ул хамаарна**”
- (14.1.a)** Дотоодын валютад “**төгрөг**” ашиглана.
- (14.2)** Валют хөрвүүлэх ханшийг тооцох огноо: “**хамаарахгүй**”
Валютын хөрвүүлэх ханшийг тогтоох эрх бүхий этгээд нь “**Монгол банк**”
- (15.1)** **ТШӨХ-д** тодорхойлсон тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш тендер нь **45** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- (15.3)** Тендерт оролцогчийн төлбөрт нэмж тооцох итгэлцүүр байгаа бол түүнийг зааж өгнө.
- (16.1)** Тендерийн баталгааны хувь хэмжээ нь
Багц – 4 Ариутгал халдвартгүйтэлийн бараа худалдан авах – 328,126 төгрөг байна.
- (17.0)** Хувилбарт тендер “**Ирүүлэхийг зөвшөөрөхгүй**”
- (19.2)** Тендер хүлээн авах захиалагчийн хаяг нь: [/tender.gov.mn/](http://tender.gov.mn) цахим хаягаар ирүүлэх
Гэрээ: **СЭМҮТ-ТЕ-2019/07-02**
- Тендер шалгаруулалт/ Гэрээний дугаар: **СЭМҮТ-ТЕ-2019/07-02**
- (20.1)** Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь **2019 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 12 цаг 00 минут** байна.

- (23.1) Тендерийг **2019 оны 05 дугаар сарын 06-ны** өдрийн **12 цаг 30 минут-д Баянзүрх дүүрэг 9 дүгээр хороо, шар хадны 50 дугаар гудамжс, Сэтгэцийн Эрүүл Мэндийн Үндэсний Төвийн, Удирдлагын байрны 2 дугаар давхарт, “Сургалтын өрөө”-нд нээнэ.**
- (29.2.г) Гэрээний хэрэгжилтийн явцад үнэ тогтмол байна.
Дараа оны тендер шалгаруулалт явагдааж, гүйцэтгэгчийн сонгох хүртэл нэмэлт гэрээ байгуулах тохиолдолд 2019 оны тендерийн баримт бичигт заасан заасан үнээр нийлүүлэх гэрээ байгуулна.
- (32.4) Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах хоног: **2019 оны 05 дугаар сарын 31-ний өдөр**
- (33.1) Гүйцэтгэлийн баталгаа ирүүлэх - **“Шаардлагагүй”**
- (34.1) Урьдчилгаа төлбөр **“Хийхгүй”**
- Захиалагч барааны тоо хэмжээг бууруулж болох хамгийн их хувь: **“30%”**
Нийлүүлэх барааны тоо хэмжээг өсгөж болох хамгийн их хувь: **“30%”**

**БҮЛЭГ IV. ТЕНДЕРИЙН МАЯГТ, ЧАДВАРЫН МЭДЭЭЛЭЛ,
ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ЭРХ ОЛГОХ МЭДЭГДЭЛ
БОЛОН ГЭРЭЭНИЙ МАЯГТ**

Үйлчилгээ үзүүлэгчийн тендер

Үйлчилгээ үзүүлэх тендерийн маягт бөглөх санамж

Тендерт оролцогч нь энэхүү тендерийн маягтыг бөглөж тендерийн хамт ирүүлнэ. Хэрэв тендерийн үнэ нь хэд хэдэн валютаар илэрхийлэгдэж байгаа бол энэ тухай дэлгэрэнгүй мэдээллийг нэмж ирүүлнэ.

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

- Бид, [тендерт оролцогчийн нэр], танай гаргасан тендерийн баримт бичгийг судалж үзээд [гэрээний нэр ба дугаар]-ыг энэ тендерийн баримт бичигт заасан гэрээний нөхцөл, үйлчилгээний үр дүнгийн тодорхойлолт, зураг болон энэ тендертэй хамт санал болгож буй үйл ажиллагааны хуваарийн дагуу [тендерийн үнийг тоогоор болон үсгээр оруулах], [төгрөг эсвэл зөвшөөрсөн валют]-аар гүйцэтгэхээр санал болгож байна.

Гэрээний төлбөрийг дараах валютаар авна. Үүнд:

№	Валютын нэр	Тус валютаар төлөх хувь	Гадаад валютын ханш /гадаад валютын нэгж хэдэн төгрөгтэй тэнцэх/	Шаардагдах гадаад валютын дүн
(а)				
(б)				

Шаардагдах урьдчилгаа төлбөр:

	Валютын нэр	Валютын дүн
(а)		
(б)		

- Энэ тендер нь тендерийн баримт бичигт шаардсаны дагуу **ТШӨХ-д** заасан хугацаанд хүчинтэй, тендерийн баталгааны шаардлагад нийцсэн гэдгийг бид үүгээр баталж байна.

3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.

Тендерт оролцогчийн нэр: _____

Эрх бүхий этгээдийн гарын үсэг: _____

Эрх бүхий этгээдийн нэр, албан тушаал: _____

Хаяг: _____

ЧАДВАРЫН МЭДЭЭЛЭЛ

Чадварын мэдээллийг бөглөх санамж

Гэрээг хэрэгжүүлэх чадвартайгаа нотлох, эсхүл урьдчилсан сонголтод ирүүлсэн мэдээлэлд орсон өөрчлөлтийг тодотгох зорилгоор тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны 4 дүгээр зүйлд заасны дагуу тендерт оролцогч дараах мэдээллийг бөглөж ирүүлнэ. Эдгээр мэдээлэл гэрээний хэсэг болохгүй. Шаардлагатай бол нэмэлт хуудас хэрэглэнэ. Хавсаргасан баримт бичиг нь тендерийг бэлдсэн хэлнээс өөр хэл дээр бол түүнийг орчуулсан байх шаардлагатай. Тендерт оролцогч урьдчилсан сонголтод оролцсон бол зөвхөн өөрчлөгдсөн мэдээллээ бөглөж ирүүлнэ.

- 1. Тендерт оролцогч болон түншлэлийн гишүүн бүр**
- 1.1. Тендерт оролцогч хуулийн этгээд болохыг нотлох баримт бичиг буюу улсын бүртгэлийн гэрчилгээ гэх мэт:
[хуулбарыг хавсаргах]
- Бүртгүүлсэн газар: [бөглөх]
- Бизнесийн үйл ажиллагааны үндсэн хаяг: [бөглөх]
- Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурсан этгээдийн итгэмжлэл: [хавсаргах]
- 1.2. Сүүлийн [тоо] жилийн хугацаанд хийж гүйцэтгэсэн үйлчилгээний нийт мөнгөн дүнг жил, жилээр жагсаах:
[бөглөх]
- 1.3. Ерөнхий гүйцэтгэгчээр сүүлийн [тоо] жилийн хугацаанд хийж гүйцэтгэсэн төрөл болон хэмжээгээр ижил төстэй үйлчилгээ ба гэрээний үнийн дүнг дээрх 1.2-т заасан валютаар илэрхийлж доорх хүснэгтэд бичнэ. Түүнчлэн амласан болон одоо гүйцэтгэж буй үйлчилгээний талаарх мэдээлэл, тэдгээрийн дуусах хугацааг жагсааж бичих.

Төслийн нэр унэ он ба улс	Захиалагч, үйлчлүүлэгчийн нэр, холбоо барих ажилтан	Гүйцэтгэсэн үйлчилгээний төрөл, дууссан
(a)		
(б)		

- 1.4. Гэрээг гүйцэтгэхэд санал болгож буй үндсэн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн нэр төрлийн талаарх мэдээллийг доорх хүснэгтээр ирүүлнэ. Мөн тендерт оролцогчдод өгөх

зааварчилгааны 4.4 (в)-г анхаар.

Тоног төхөөрөмжийн нэр төрөл	Тодорхойлолт, үйлдвэрлэсэн, ашиглагдсан хугацаа (жилээр)	Ашиглалтын байдал (шинэ, сайн, хуучин), ба тоо ширхэг	Өөрийн, түрээслэх (хаанаас?) эсхүл худалдаж авах (хаанаас?),
(а)			
(б)			

- 1.5. Гэрээнд санал болгож буй удирдах болон гүйцэтгэх /техникийн/ голлох мэргэжилтний чадвар, туршлага. Намтрыг хавсаргана. Мөн тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны 4.4 (г) ийг анхаар.

Албан тушаал	Нэр	Ажилласан жил (нийт)	Санал болгож буй албан тушаалтай ижил албан тушаалд ажилласан жил
(а)			
(б)			

- 1.6. Санал болгож буй туслан гүйцэтгэгч. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг анхаар.

Үзүүлэх үйлчилгээ	Туслан гүйцэтгэх	Туслан гүйцэтгэгч (нэр болон хаяг)	Ижил үйлчилгээ	төстэй үзүүлж байсан туршлалга
(а)				
(б)				

- 1.7. Санхүүгийн чадавхийг харуулах аудитаар баталгаажуулсан сүүлийн [too] жилийн санхүүгийн тайлан, ашиг орлого, алдагдлын болон санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлтийн хамт. Дор жагсааж хувийг хавсаргана.

- 1.8. Чадварын шаардлагыг хангахад шаардагдаж болох санхүүгийн эх үүсвэрийн нотолгоо: бэлэн мөнгө, зээл авах баталгаа гэх мэт. Дор жагсааж үндсэн баримт бичгийн хувийг хавсаргана.
- 1.9. Тендерт оролцогчийн харилцагч банкны нэр, хаяг болон утас, телекс, факсын дугаар.
- 1.10. Тендерт оролцогчийн одоогийн ба сүүлийн [тоо] жилийн хугацаанд оролцсон аливаа шүүхийн зарга, маргааны талууд ба нэхэмжлэлийн мөнгөн дүн, шийдэгдсэн байдал.

Нөгөө тал(ууд)	Маргааны шалтгаан	Шийдэгдсэн байдал	Нэхэмжлэлийн мөнгөн дүн
(a)			
(b)			

- 1.11. Тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны 3.3-т заасан эрх бүхий тендерт оролцогчийн шаардлагыг хангаж байгаа тухай мэдэгдэл.
- 1.12. Санал болгож буй хөтөлбөр (үйлчилгээний ажлын арга хэлбэр ба хуваарь). Тендерийн баримт бичгийн шаардлагыг хангаж байгааг харуулах дэлгэрэнгүй тодорхойлолт, шаардлагатай бол зураг болон бүдүүвч график.

2. Түншлэл

- 2.1. Чадварын мэдээллийн 1.1-1.11-д дурдсан бүх мэдээллийг түншлэлийн гишүүн тус бүрээр гаргаж ирүүлнэ.
- 2.2. Чадварын мэдээллийн 1.12-т дурдсан мэдээллийг түншлэлийн хувьд гаргаж ирүүлнэ.
- 2.3. Түншлэлийн нэрийн өмнөөс тендерт гарын үсэг зурах эрх бүхий этгээдийн итгэмжлэлийг хавсаргана.

2.4. Дор дурдсан шаардлагыг хангасан бөгөөд түншлэлийн бүх гишүүдийн хооронд байгуулсан гэрээг (энэхүү= гэрээ нь түншлэлийн бүх гишүүдийн хувьд хуулийн хүчин төгөлдөр байх) хавсаргана. Үүнд:

- (а) Гэрээний нөхцөлийн дагуу гэрээг хэрэгжүүлэхэд бүх гишүүд хамтран болон тус тусдаа хүлээх хариуцлагыг тодорхой заасан байх;
- (б) Түншлэлийн аль нэг болон бүх гишүүдийн нэрийн өмнөөс үүрэг хүлээх, зааварчилгаа хүлээн авахад тэдгээрийг төлөөлөх эрх бүхий нэг гишүүн томилсон байх;
- (в) Гэрээний нийт гүйцэтгэл, түүний дотор төлбөрийг зөвхөн төлөөлөх эрх бүхий гишүүнтэй тооцох.

3. Нэмэлт шаардлага

3.1. Тендерт оролцогч нь **ТШӨХ-д** шаардсан аливаа нэмэлт мэдээллийг гаргаж ирүүлэх болон тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны 4.1 дугаар зүйлд заасан шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл

[Захиалагч байгууллагын хэвлэмэл хуудсыг ашиглана]

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг бичих стандарт маягтын тухай санамж

Тендерт оролцогчид өгөх зааварчилгааны 32, 33 дугаар зүйлд зааснаар гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл нь гэрээ байгуулах хэлцэл хийгдсэн гэж үзэх үндэслэл болно. Захиалагч энэхүү гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийн маягтыг үнэлгээ дуусаж холбогдох зөвшөөрөл авсаны дараа бөглөж зөвхөн шалгарсан тендерт оролцогчид илгээнэ.

[Огноо]

[Гүйцэтгэгчийн нэр]-ийн дарга _____ Танаа

Гэрээ байгуулах эрх олгох тухай

[Гэрээний тусгай нөхцөлд заасан тендер шалгаруулалт/ гэрээний нэр ба дугаар]-г гүйцэтгэхээр [огноо]-нд ирүүлсэн танай тендерийг тендерт оролцогчдод өгөх зааварчилгаанд тусгасны дагуу залруулга, тохируулга хийсэн байдлаар [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] –ийн гэрээний үнэтэйгээр манай байгууллага хүлээн зөвшөөрснийг үүгээр мэдэгдье.

Энэхүү мэдэгдлийг хүлээн авснаас хойш [too] хоногийн дотор гэрээний маягад гарын үсэг зурж ирүүлнэ үү.

Шаардлага хангасан гүйцэтгэлийн баталгааг энэхүү мэдэгдэл хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор ирүүлээгүй нь гэрээ байгуулах эрхийг хүчингүй болгох үндэслэл болно.

Гэрээний маягт, нөхцөлүүдийг хавсаргав.

Захиалагч байгууллагын нэр: _____

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга: _____

Албан тушаал, нэр: _____

Хаяг: _____

Гэрээний Маягт

[Захиалагч байгууллагын хэвлэмэл хуудсыг ашиглана]

НИЙТ ҮНЭД ҮНДЭСЛЭСЭН ГЭРЭЭ

БАТЛАВ.

ЗӨВШӨӨРСӨН¹.

ЗАХИАЛАГЧ

ГҮЙЦЭТГЭГЧ

[Санхүүжилтийн эрхийг нээх байгууллага, удирдах албан тушаалтан]

(Тамга, тэмдэг)

(Тамга, тэмдэг)

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Гарын үсэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

(Албан тушаал)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

.....

хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [Үйлчилгээ гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож [он] оны [cap] __ сарын [өдөр] -ний өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

[Санамж: Доор хашиттад бичсэн текстүүд нь зөвхөн гэрээг бэлтгэхэд заавар өгөх зорилготой бөгөөд эдгээр бүх санамжуудыг эцэст нь устгахыг анхаарна уу. Хэрэв үйлчилгээ үзүүлэгч нь нэгээс илүү этгээдээс бурдээж байгаа бол гэрээний дээр дурдсан хэсэгт дараах нэмэлтийг хэсэгчлэн өөрчилнө: “...(цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас захиалагчид үзүүлэх бүх үүрэг хариуцлагыг хамтран болон тус тусдаа хариуцан үүрэг хүлээх дараах, ... [Үйлчилгээ гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] ... байгууллагуудаас бурдсэн түншлэл (цаашид “гүйцэтгэгч” гэх.)”]

ҮҮГЭЭР

- (а) Захиалагч үйлчилгээ үзүүлэгчээс энэ гэрээнд тусгагдсан гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд тодорхойлсон үйлчилгээг (цаашид “үйлчилгээ” гэх) үзүүлэхийг шаардсаны дагуу;
- (б) Үйлчилгээ үзүүлэгч нь энэ гэрээнд заасан нөхцөлийн дагуу [гэрээний үнийг тоогоор болон усгээр бичих] төгрөгөөр гүйцэтгэхэд шаардлагатай мэргэжлийн ур чадвар, боловсон хүчин болон техникийн нөөц түүнд байгааг Захиалагчид илэрхийлсэний дагуу ;
- (с) Захиалагч нь [санхүүжилтийн эх үүсвэр]-ээс гэрээгээр үзүүлэх үйлчилгээний төлбөрийг уг гэрээнд заасан нөхцөл, болзлын дагуу үйлчилгээ үзүүлэгчид төлнө;

Иймд талууд дараах зүйлсийг харилцан тохиролцлов:

1. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний хэсэг болох бөгөөд гэрээнд хавсаргана (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
 - (а) Гэрээ багуулах эрх олгох тухай мэдэгдэл
 - (а) Тендерт оролцогчийн тендер
 - (а) Гэрээний ерөнхий нөхцөл;
 - (б) Гэрээний тусгай нөхцөл;
 - (в) Үйлчилгээ үзүүлэгчийн тендер /маягтын дагуу/
 - (г) Үнэлэгдсэн үйл ажиллагааны хуваарь
 - (д) Үйлчилгээний үр дүнгийн тодорхойлолт
 - (е) Дараах хавсралтууд: [Санамж: Эдгээр хавсралтаас ашиглаагүй хавсралтын дор дурдсан гарчиг болон уг гарчигийг бичсэн хавсралт хуудсанд “Ашиглахгүй” гэж бичнэ.]

ГҮЙЦЭТГЭЛД НӨХӨН ТӨЛБӨР ХИЙХЭД ШААРДЛАГАТАЙ ХАВСРАЛТУУД

Хавсралт А: Үйлчилгээний , танилцуулга, тодорхойлолт

Хавсралт Б: Төлбөрийн хуваарь

Хавсралт В: Голлох боловсон хүчин болон туслан гүйцэтгэгч

Хавсралт Г: Гадаад валютаар төлөгдөх гэрээний үнийн задаргаа

Хавсралт Д: Дотоод валютаар төлөгдөх гэрээний үнийн задаргаа

Хавсралт Е: Захиалагчаас хангах хэрэгсэл ба үйлчилгээ

Гэрээ нь энд дурдсан үйлчилгээг хийж гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно.

1. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг, хариуцлагыг хүлээнэ.
2. Гүйцэтгэгч нь энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан үйлчилгээг гүйцэтгэж, гэрээний явцад гарсан зөрчил, гологдол арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.
3. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх үйлчилгээ болон илэрсэн аливаа зөрчил, гологдол арилгасныг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.
4. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.
5. Дараа оны тендер шалгаруулалт явагдаж, гүйцэтгэгчийн сонгох хүртэл нэмэлт гэрээ байгуулах тохиолдолд 2018 оны тендерийн баримт бичигт заасан заасан үнээр нийлүүлэх гэрээ байгуулна.

Талууд энэхүү гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулмагц холбогдох этгээд гэрээг зөвшөөрч гарын үсэг зурсан өдрөөс эхлэн энэ гэрээ хүчин төгөлдөр болно.

[Захиалагчийн нэр]-ийг төлөөлж

[Төлөөлөх эрх бүхий этгээд]

[Үйлчилгээ үзүүлэгчийн нэр]-ийг төлөөлж

[Төлөөлөх эрх бүхий этгээд]

[Санамж: Хэрэв үйлчилгээ үзүүлэгч нь нь нэгээс дээш этгээд байх бол тэдгээрийн бүх гишүүд өөрсдийн нэрийн өмнөө төлөөлж гарын үсэг зурах ёстой.:]

Үйлчилгээ үзүүлэгчийн гишүүнийг төлөөлж

[Гишүүний нэр]

[Төлөөлөх эрх бүхий этгээд]

[Гишүүний нэр]

[Төлөөлөх эрх бүхий этгээд]

БҮЛЭГ V. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

Гэрээний ерөнхий нөхцөлийн санамж

Үйлчилгээ үзүүлэх гэрээний үед ашиглах энэхүү жишиг гэрээний нөхцөлүүдийг захиалагч үйлчилгээний төлбөрийг нийт үнэд үндэслэсэн хийх нөхцөлөөр гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж ажиллахад ашиглана.

Нийт үнийн гэрээ нь үйлчилгээ үзүүлэгчийн хийх ажил, үүргүүд нь тодорхой, ойлгомжтой бөгөөд үйлчилгээ үзүүлэгчийн хүлээх арилжааны эрсдэл харьцангуй бага байх тохиолдолд буюу үйлчилгээ үзүүлэгч тухайн үйлчилгээний даалгаврыг урьдчилан тохирсон нийт үнээр гүйцэтгэх боломжтой тохиолдолд хэрэглэгддэг. Энэхүү үнэ нь үйлчилгээ үзүүлэгчийн ирүүлсэн үнэ буюу түүний зардлын үнэлгээнд үндэслэнэ. Захиалагч нь тодорхой үр дүн буюу гарцтай нягт уялдуулсан төлбөрийн хуваарийн дагуу үйлчилгээ үзүүлэгчид санхүүжилтийг хийх ёстой. Нийт үнийн гэрээний давуу тал нь гэрээний удирдлагыг харьцангуй хялбарчилдаг бөгөөд захиалагч боловсон хүчний хангамжид оролцохгүйгээр зөвхөн тэдний үзүүлсэн үйлчилгээний үр дүнг хянаж зохицуулдаг.

Гэрээ нь дөрвөн хэсэгтэй: Гэрээний маягт, Гэрээний Ерөнхий нөхцөл, Гэрээний тусгай нөхцөл, болон хавсралтууд. Захиалагч нь гэрээний ерөнхий нөхцөлд шууд өөрчлөлт хийж болохгүй тухайн үйлчилгээний онцлог шинж чанартай холбоотой өөрчлөлт тохируулгыг зөвхөн гэрээний тусгай нөхцөлд тусгана.

БҮЛЭГ V. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. Ерөнхий заалт

1.1 Нэр томьёо

Энэхүү гэрээнд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

- (а) “Үйл ажиллагааны хуваарь” гэж гүйцэтгэгчээс үзүүлэх бүх үйлчилгээний нэр төрлийг үнэлж тендерийн хамт ирүүлсэн жагсаалтыг хэлнэ;
- (б) “Үйлчилгээ дууссан өдөр” гэж гүйцэтгэгч үйлчилгээг гүйцэтгэж дууссаныг захиалагч гэрчилсэн өдрийг хэлнэ;
- (в) Гэрээ гэж захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулан гарын үсэг зурж энэхүү ерөнхий нөхцөл болон уг гэрээний 1 дэхь хэсэгт дурдсан баримт бичгүүдийг хавсаргасан гэрээг хэлнэ;
- (г) “Гэрээний үнэ” гэж энэ гэрээний 6 дугаар зүйлийн дагуу үйлчилгээний үр дүнд үндэслэн төлөх үнийг хэлнэ;
- (д) “Ажил-өдөр” гэж үйлчилгээ үзүүлэгчийн холбогдох удирдлагын болон материалын зардлаас гадна түүний ажиллах хүч болон тоног төхөөрөмжийн ажилласан хугацаанаас хамааран төлөгдөх төлөвлөөгүй зардлыг хэлнэ.
- (е) “Захиалагч” гэж үйлчилгээ үзүүлэгчийг хөлслөн ажиллуулж буй этгээдийг хэлнэ.
- (ё) “Гадаад валют” гэж төгрөгөөс өөр валютыг хэлнэ;
- (ж) “ГЕН” гэж эдгээр ерөнхий нөхцөлийг хэлнэ;
- (з) “Засгийн газар” гэж Монгол улсын Засгийн газрыг;
- (и) “Дотоодын валют” гэж төгрөгийг хэлнэ;
- (й) “Гишүүн” гэж үйлчилгээ үзүүлэх этгээд нь нэгээс олон байгууллагууд хамтран түншлэл болсон тохиолдолд түншлэлийн аливаа нэг байгууллагыг; “Гишүүд” гэж тэдгээр бүх байгууллагыг; “Төлөөлөх эрх бүхий гишүүн” гэж харин энэхүү гэрээний дагуу захиалагчийн өмнө үйлчилгээ үзүүлэгчийн хүлээх бүх эрх, үүрэг хариуцлагыг тэдний өмнөөс төлөөлөхөөр гэрээний тусгай нөхцөлд тодорхойлсон байгууллагыг“;
- (к) “Тал” гэж Захиалагч эсхүл үйлчилгээ үзүүлэгч этгээдийг, харин “Талууд” гэж эдгээрийг хоёуланг нь ойлгоно;
- (л) “Боловсон хүчин” гэж тухайн үйлчилгээг эсхүл түүний зарим хэсгийн ажлыг гүйцэтгүүлэхээр үйлчилгээ үзүүлэгчийн эсхүл аливаа туслан гүйцэтгэгчийн томилон ажиллуулсан хүмүүсийг хэлнэ;
- (м) “Үйлчилгээ үзүүлэгч” гэдэг нь үйлчилгээ үзүүлэх тендерийг нь захиалагч хүлээн зөвшөөрсөн этгээдийг хэлнэ;

- (н) “Үйлчилгээ үзүүлэгчийн тендер” гэж Үйлчилгээ үзүүлэгчийн бэлтгэж Захиалагчид ирүүлсэн тендерийг хэлнэ;
- (о) “ГТН” гэж ГЕН-д нэмэлт өөрчлөлт оруулсан эсхүл тодотгосон энэ гэрээний тусгай нөхцөлийг хэлнэ;
- (ө) “Үйлчилгээний үр дүнгийн тодорхойлолт” гэж Үйлчилгээ үзүүлэгчээс захиалагчид ирүүлсэн тендерийн бүрэлдэхүүнд багтсан үйлчилгээний тодорхойлолтыг хэлнэ;
- (р) “Үйлчилгээ” гэж Үйлчилгээ үзүүлэгчийн тендерт тусгасан үйлчилгээний тодорхойлолт, үйл ажиллагааны хуваарь болон гэрээний хавсралт А-д нийцүүлэн энэхүү гэрээний дагуу үйлчилгээ үзүүлэгчийн гүйцэтгэх ажлыг;
- (с) “Туслан гүйцэтгэг” гэж 3.5 болон 4 дүгээр зүйлийн дагуу үйлчилгээний зарим хэсгийг туслан гүйцэтгүүлэхээр Үйлчилгээ үзүүлэгчийн гэрээ байгуулсан этгээдийг;

1.2 Гэрээний хууль

Гэрээний тусгай нөхцөл(ГТН)-д өөрөөр тусгайлан заагаагүй бол энэхүү гэрээ нь Монгол улсын хуулиар зохицуулагдана.

1.3 Гэрээний хэл

Энэ гэрээ нь ГТН-д тусгайлан заасан хэлээр бичигдэнэ. Энэ нь гэрээний агуулга, тайлбартай холбоотой аливаа асуудлыг шийдвэрлэхэд ашиглах хэл байна.

1.4 Мэдэгдэл

Энэ гэрээний дагуу хийгдэх аливаа мэдэгдэл, хүсэлт, эсхүл зөвшөөрлийг бичгээр үйлдэж түүнийг харилцагч талын төлөөлөх эрх бүхий этгээдэд ГТН-д заасан хаягаар нь баталгаат шуудан, эсхүл факсаар хүргэгдсэн үед хийгдсэн гэж үзнэ.

1.5 Байршил

Үйлчилгээ нь Хавсралт А, болон үйлчилгээний үр дүнгийн Тодорхойлолтод заасан газар хийгдэх ба тодорхой ажлын байршил тусгайлан заагдаагүй бол захиалагчийн баталсан байршилд хийгдэнэ.

1.6 Төлөөлөх эрх бүхий этгээд

Энэ гэрээний дагуу захиалагч эсхүл үйлчилгээ үзүүлэгчийн хэрэгжүүлэх шаардлагатай буюу зөвшөөрөгдсөн аливаа арга хэмжээ болон боловсруулах шаардлагатай аливаа баримт бичгийг зөвхөн ГТН-д заасан албан тушаалтнууд гүйцэтгэж эсхүл боловсруулж болно.

1.7 Засгийн газрын хяналт шалгалт

Үйлчилгээ үзүүлэгч гэрээний санхүүжилтийг хариуцаж буй засгийн газрын холбогдох байгууллагын шаардсанаар үйлчилгээний хэрэгжилт, үр дүнтэй холбоотой аливаа бүртгэл, тайланг шалгуулах, түүний томилсон аудитороор үр дүнгийн хяналт хийлгэхийг зөвшөөрөх үүрэгтэй.

1.8 Татвар хураамж

Үйлчилгээ үзүүлэгч, туслан гүйцэтгэгчид болон тэдний ажилтан холбогдох хууль, тогтоомжийн дагуу ногдох аливаа татвар, хураамжийг төлөх үүрэгтэй бөгөөд энэ дүнг гэрээний үнэд багтсан гэж үзнэ.

2. Гэрээг эхлэх, дуусгах, өөрчлөх болон цуцлах

2.1 Гэрээ хүчин төгөлдөр болох	Энэхүү гэрээ нь хоёр тал гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс эсхүл ГТН-д заасан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.
2.2 Үйлчилгээг эхлүүлэх	
2.2.1 Хөтөлбөр	Үйлчилгээ үзүүлэгч нь өөрийн гүйцэтгэх бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт болон хугацааг харуулсан Хөтөлбөр гаргаж үйлчилгээг эхлүүлэхээс өмнө захиалагчид гарган өгч батлуулна.
	Үйлчилгээ нь батлагдсан хөтөлбөр түүний тодотголын дагуу хийгдэнэ.
2.2.2 Эхлэх огноо	Үйлчилгээ үзүүлэгч нь тухайн үйлчилгээг гэрээ батлагдсанаас хойш (30) хоногийн дараа эсхүл гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр үзүүлж эхэлнэ.
2.3 Дуусгахаар төлөвлөсөн өдөр	2.6 дугаар зүйлд заасны дагуу хугацаанаас нь өмнө гэрээг цуцалснаас бусад тохиолдолд тухайн Үйлчилгээ үзүүлэгч нь үйл ажиллагаагаа ГТН-д тодорхойлсон дуусгахаар төлөвлөсөн өдөрт дуусгана. Хэрэв үйлчилгээ үзүүлэгч нь дуусгахаар төлөвлөсөн өдөр гэхэд үйл ажиллагаагаа дуусгаагүй бол 3.8 дах хэсэгт заасны дагуу алданги төлнө.
2.4 Нэмэлт өөрчлөлт	Энэ гэрээний цар хүрээ, үнэтэй холбоотой болон бусад нөхцөл болзолд оруулах өөрчлөлт нь зөвхөн талуудын бичгээр үйлдсэн тохиролцоонд үндэслэх ба гэрээний санхүүжилтийг хариуцаж буй засгийн газрын холбогдох байгууллагын зөвшөөрөл авсанаар уг тохиролцоо нь хүчин төгөлдөр болно.
2.5 Форсе-Мажор	
2.5.1 Тодорхойлолт	Энэ гэрээний зорилгын хүрээнд аль нэг талын боломжит хяналтаас гадуур давагдашгүй хүчний шинжтэй байдал бий болж энэ гэрээний дагуу хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх боломжгүйд хүрэх эсхүл тодорхой нөхцөл байдлыг улмаас боломжгүй гэж үзэж болохоор нөхцөл байдал үүссэнийг Форсе-Мажор гэж ойлгоно.
2.5.2 Гэрээг зөрчөөгүй гэж үзэх	Форсе-Мажор нөхцөл байдлын улмаас гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлж чадаагүй талыг дараах тохиолдолд энэ гэрээг зөрчсөн гэж үзэхгүй. Үүнд: Уг нөхцөл байдалд өртсөн тал нь а/ түүнээс урьдчилан сэргийлэх, санаа тавих, өөр хувилбар хайх зэргээр гэрээний нөхцөл болзлыг хангахын тулд болмжит бүх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн,

б/ энэхүү нөхцөл байдал үүссэн талаар нөгөө талдаа аль болох урьдаас урьдчилан мэдэгдсэн байна.

2.5.3 Хугацаа сунгах

Форсе-Мажор нөхцөлийн үүссэнд гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу үйл ажиллагаагаа явуулах боломжгүй байсан тэр хугацаагаар уг талын гэрээ дуусгах хугацааг сунгана.

2.5.4 Төлбөр

Форсе-Мажор нөхцөлийн үлмаас гэрээг хэрэгжүүлэх боломжгүй байсан хугацааны туршид үйлчилгээ үзүүлэгчийг энэ гэрээнд заасан нөхцөлөөр үргэлжлүүлэн санхүүжүүлэх бөгөөд энэхүү гэрээний зорилгоор зайлшгүй шаардлагын үлмаас бодитойгоор гарсан болон уг хугацааны эцэст үйлчилгээг дахин сэргээхэд гарсан нэмэлт зардалд захиалагч нөхөн төлбөр хийнэ.

2.6 Гэрээг цуцлах

2.6.1 Захиалагч гэрээг цуцлах

Захиалагч энэ 2.6.1. зүйлийн (а)-(е) –д заасан аливаа нөхцөл байдал үүссэн тохиолдолд (30), харин (ё)-д заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд (60) –аас багагүй хоногийн өмнө гэрээг цуцлах тухай мэдэгдлийг бичгээр хүргүүлсний үндсэн дээр гэрээг цуцлаж болно:

- (а) Хэрэв үйлчилгээ үзүүлэгч нь Гэрээний дагуу хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх явцдаа гаргасан алдааг захиалагч илрүүлж түүнд мэдэгдсэнээс хойш 30 хоногийн хугацаанд эсхүл захиалагчийн бичгээр гаргасан мэдэгдэлд 30 хоногоос илүүгээр заасан хугацаанд багтаж залруулаагүй бол;
- (б) Үйлчилгээ үзүүлэгч нь төлбөрийн чадваргүй болсон эсхүл дампуурсан бол;
- (в) Хэрэв форсе-мажор нөхцөлөөс үүдэн Үйлчилгээ үзүүлэгч нь тухайн үйлчилгээний үндсэн хэсгийг (60)-аас багагүй хоногийн дотор хийж гүйцэтгэх боломжгүй болсон; эсхүл
- (г) Хэрэв үйлчилгээ үзүүлэгч нь тухайн гэрээг хэрэгжүүлэх болон гэрээ байгуулах эрх олж авах явцдаа авилга, эсхүл залилан мэхлэх үйл ажиллагаанд холбогдсон нь шүүх эсхүл холбогдох байгууллагаар нотлогдсон бол.
- (д) Хэрэв үйлчилгээ үзүүлэгч нь 3.9 дэх зүйлд нийцсэн Гүйцэтгэлийн баталгаа ирүүлээгүй бол;

- (e) Хэрэв үйлчилгээ үзүүлэгч нь гэрээг дуусгавар болгох хугацааг хойшлуулсанаас болж ГТН болон 3.8.1.-д заасны дагуу захиалагчид төлөгдөх алдангийн дээд хувь хэмжээнд хүрсэн тохиолдолд;
- (ë) Хэрэв захиалагч шаардлагатай гэж үзсэн тохиолдолд бие даан гэрээг цуцлах шийдвэр гаргаж болно.

2.6.2 Үйлчилгээ

үзүүлэгч гэрээг цуцлах

Үйлчилгээ үзүүлэгч нь 2.6.2. зүйлийн (а) болон (б) –д заасан аливаа нөхцөл байдал үссэн тохиолдолд (30)-аас багагүй хоногийн өмнө гэрээг цуцлах тухай мэдэгдлийг Захиалагчид бичгээр хүргүүлсний үндсэн дээр гэрээг цуцлаж болно:

- (a) Хэрэв захиалагч нь энэ гэрээний дагуу төлбөрөө төлөөгүй бөгөөд төлбөр хийх хугацаа хэтэрсэн тухай үйлчилгээ үзүүлэгчийн бичгээр гаргасан мэдэгдлийг хүлээн авсанаас хойш (45) хоногт багтаан 7 дугаар зүйлд заасны дагуу үл маргалдах журмаар төлбөр хийгээгүй бол; эсхүл
- (б) Хэрэв Үйлчилгээ үзүүлэгч нь Форс-мажор нөхцөлийн улмаас (60)-аас багагүй хоногоор үндсэн үйлчилгээг гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд.

2.6.3 Гэрээ

цуцлагдсан үед хийгдэх төлбөр

Энэхүү гэрээний 2.6.1 эсхүл 2.6.2 нөхцөлийн дагуу гэрээг цуцлагдсан үед захиалагч дараах төлбөрийг Үйлчилгээ үзүүлэгчид төлнө:

- (a) 6 дугаар зүйлийн дагуу төлөх үйлчилгээг цуцлах болсон өдөр хүртлэх хугацаанд хангалттай гүйцэтгэсэн ажлын хөлс;
- (б) 2.6.1 дэх зүйлийн (а), (б), (г), (д), (е) хэсэгт заасны дагуу гэрээ цуцлагдсанаас бусад тохиолдолд гэрээ цуцласантай холбогдож гарсан бодит шууд зардлын нөхөн төлбөр

3. Үйлчилгээ үзүүлэгчийн эрх үүрэг

3.1 Ерөнхий зүйл

Үйлчилгээ үзүүлэгч нь үйл ажиллагааны хуваарь болон техникийн тодорхойлолтод заасны дагуу үйлчилгээг үзүүлэхдээ нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн арга техник болон практик зарчмын дагуу өөрийн үргийг хэмнэлттэй, үр ашигтай, чармайлт гарган гүйцэтгэх ба сайн удирдлага, зохион байгуулалттайгаар ажиллаж аюулгүй арга хэлбэр, тохиромжит дэвшилтэт технологийг ашиглана. Үйлчилгээ үзүүлэгч нь энэхүү гэрээний эсхүл үйлчилгээнд хамаарах үйл ажиллагаа

явуулахдаа захиалагчид ямагт шударга зөвлөгөө өгөх бөгөөд туслан гүйцэтгэгч эсхүл гуравдагч этгээдтэй харилцах аливаа асуудалд хандахдаа ямагт захиалагчийн хууль ёсны эрх сонирхлыг хамгаалж, дэмжиж ажиллана.

[Энэ хэсэгт Хяналт шалгалтад баримтлах зарчим болон арга хэлбэрийг тодорхойлж оруул]

3.2 Сонирхлын зөрчилдөөн

3.2.1 Үйлчилгээ үзүүлэгч нь аливаа урамшуулал, хөнгөлөлтөөс ашиг хүртэхгүй байх.

6 дугаар зүйлийн дагуу үйлчилгээ үзүүлэгчид төлөх үйлчилгээний нийт хөлс нь зөвхөн энэ гэрээ буюу үйлчилгээтэй холбогдож төлөгдөх үйлчилгээ үзүүлсэний төлбөр байх бөгөөд Үйлчилгээ үзүүлэгч нь энэ гэрээний дагуу, эсхүл гэрээний үүргээ биелүүлэхэд хэрэгжүүлсэн аливаа үйл ажиллагаатай холбогдуулж өөрт ашигтайгаар урамшуулал, хөнгөлөлт, болон ижил төстэй төлбөрийг бусад этгээдээс авахыг үл зөвшөөрнө. Үйлчилгээ үзүүлэгч нь мөн өөрийн ажилтан болон туслан гүйцэтгэгчид, холбогдох бусад хамтрагчдыг дээрхтэй ижил төстэй нэмэлт хөлс авахгүй байх явдлыг хангахын төлөө ажиллана.

3.2.2 Үйлчилгээ үзүүлэгч болон түүний хамтрагч нь төсөлд өөр сонирхолтойгоор оролцохгүй байх

Үйлчилгээ үзүүлэгч болон түүний хамтрагч, түүнчлэн аливаа туслан гүйцэтгэгч болон түүний хамтрагч нь гэрээг хэрэгжүүлэх хугцаанд болон гэрээний хэрэгжилт дууссанаас хойш энэхүү үйлчилгээ болон үүнтэй нягт холбоотой бусад төслийн бараа, ажил, үйлчилгээ (энэхүү гэрээгээр үзүүлж байгаа үйлчилгээнээс бусад үйлчилгээ)-ний гүйцэтгэгч, нийлүүлэгч байх эрхгүй.

3.2.3 Зөрчилтэй үйл ажиллагаанд оролцохыг хориглох

Үйлчилгээ үзүүлэгч эсхүл түүний туслан гүйцэтгэгч эсхүл тэдгээрийн ажилтан дараах үйл ажиллагаанд шууд болон шууд бусаар оролцохыг хориглоно. Үүнд:

- Гэрээний хэрэгжилтийн хугацаанд гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу гүйцэтгэж буй үйл ажиллагаатай зөрчилдөх аливаа бизнесийн эсхүл мэргэжлийн үйл ажиллагаа явуулах;
- Гэрээний хэрэгжилтийн хугацаанд үйлчилгээ үзүүлэгч эсхүл түүний туслан гүйцэтгэгчийн зүгээс төрийн албан хаагчийг гэрээний дагуу явуулах аливаа үйл ажиллагааг гүйцэтгэх үндсэн ажилтнаар хөлсөлж ажиллуулах;
- Энэхүү гэрээ дууссанаас хойш гэрээний тусгай нөхцөлд заасан бусад үйл ажиллагаа явуулах.

3.3 Нууцлал

Үйлчилгээ үзүүлэгч, түүний туслан гүйцэтгэгч болон тэдгээрийн ажилтан нь тухайн гэрээ, төсөл, үйлчилгээ болон Захиалагчийн үйл ажиллагаатай холбоотой өмчлөлийн болон нууц мэдээллийг гэрээний хэрэгжилтийн явцад болон гэрээг хэрэгжүүлж дууссанаас хойш (2) жилийн хугацаанд захиалагчийн бичгээр урьдчилан өгсөн зөвшөөрөлгүйгээр бусдад задруулахыг хориглоно.

3.4 Үйлчилгээ үзүүлэгчийн хариуцах даатгал	Үйлчилгээ үзүүлэгч нь (а) ГТН-д заасан эрсдэлийн эсрэг захиалагчийн зөвшөөрсөн нөхцөлөөр өөрийн/ байгаа бол туслан гүйцэтгэгчийн зардлаар/ зардлаар даатгуулах бөгөөд (б) захиалагчийн хүсэлтээр даатгуулсан тухай болон даатгалын төлбөр хийсэн талаарх нотлох баримтыг захиалагчид хүргүүлж болно.
3.5 Үйлчилгээ үзүүлэгч захиалагчаас урьдчилан зөвшөөрөл авах шаардлагатай үйл ажиллагаа	Үйлчилгээ үзүүлэгч нь дараахь үйл ажиллагааны аль нэгийг явуулахын өмнө Захиалагчаас заавал бичгээр урьдчилан зөвшөөрөл авна. Үүнд: <ul style="list-style-type: none"> (а) Үйлчилгээний аль нэг хэсгийг туслан гүйцэтгүүлэх бол, (б) Хавсралт В (“Голлох боловсон хүчин ба Туслан гүйцэтгэгчид”)-д нэр нь ороогүй боловсон хүчин/ажилтанг томилж ажиллуулах, (в) Үйл ажиллагааны хөтөлбөрийг өөрчлөх, (г) ГТН-д дурдсан бусад арга хэмжээ авах.
3.6 Тайлاغнах үүрэг хариуцлага	Үйлчилгээ үзүүлэгч нь Хавсралт В-д тодорхойлсон тайлан, баримт бичгүүдийг уг хавсралтад заасан хугацаанд, заасан маягтаар ирүүлнэ.
3.7 Үйлчилгээ үзүүлэгчийн бэлтгэсэн баримт бичгүүд нь Захиалагчийн өмч байх	3.6 дугаар зүйлийн дагуу үйлчилгээ үзүүлэгчийн ирүүлсэн бүх төлөвлөгөө, зураг, техникийн тодорхойлолт, загвар, тайлан бусад баримт бичиг болон программ хангамж нь захиалагчийн өмч болж үлдэх бөгөөд Үйлчилгээ үзүүлэгч нь эдгээрийг холбогдох бүртгэлийн хамт тухайн гэрээ дуусгавар болохоос эсхүл гэрээний хугацаа дуусахаас өмнө захиалагчид ирүүлэх үүрэгтэй. Үйлчилгээ үзүүлэгч нь эдгээр баримт бичиг болон програм хангамжийн хуулбарыг авч үлдэж болно. Гэхдээ авч үлдсэн тохиолдолд түүнийг ГТН-д заасан хязгаарлалтын хүрээнд цаашид ашиглаж болно.
3.8 Алданги	
3.8.1 Алдангийн төлбөр	Үйлчилгээ үзүүлэгч нь үйлчилгээний гэрээг дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд ГТН-д заасан хувь хэмжээгээр алданги төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.
3.8.2 Илүү төлбөрийг буцаан олгох	Хэрэв алданги төлснөөс хойш ажил дуусгахаар төлөвлөсөн хугацааг сунгасан бол төслийн менежер гүйцэтгэгчийн илүү төлсөн алдангийг дараагийн төлбөрийн мэдэгдэлд тооцох замаар залруулна. Илүү төлсөн алдангид алдангийн төлбөр хийсэн өдрөөс алдангийг буцаан төлөгдсөн өдөр хүртэл хугацааны хүүг 6.5-д заасан хувиар тооцож гүйцэтгэгчид төлнө. Хэрэв үйлчилгээ үзүүлэгч нь Захиалагчийн мэдэгдэлд заасан хугацаанд гаргасан алдаа дутагдлыг арилгаагүй бол үйлчилгээ үзүүлэгч хангалтгүй үр дүнгийн торгууль төлнө. Үйлчилгээ
3.8.3 Хангалтгүй үр дүнгийн торгууль	

үзүүлэгчийн төлөх торгуулийн хувь хэмжээг 7.2 дугаар зүйлд заасны дагуу алдаа дутагдлыг арилгахад гарах зардлын тодорхой хувиар тооцно.

3.9 Гүйцэтгэлийн баталгаа

Үйлчилгээ үзүүлэгч нь гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэлд заасан хугацаанаас хоцролгүй гүйцэтгэлийн баталгааг захиалагчийн хүлээн зөвшөөрөх дүн, маягт, банкаар гаргуулан, гэрээний үнийг төлөх валютаар илэрхийлэн захиалагчид ирүүлнэ. Гүйцэтгэлийн баталгаа нь ажил дууссан тухай мэдэгдэл гарсан өдрөөс хойш 28 хоног хүртэлх хугацаанд хүчинтэй байна.

4. Уйлчилгээ үзүүлэгчийн боловсон хүчин

4.1 Боловсон хүчиний тодорхойлолт

Үйлчилгээ үзүүлэгчийн голлох боловсон хүчиний албан тушаал, санал болгож буй ажлын байрны тодорхойлолт, чадварын доод шаардлагууд болон үйлчилгээг гүйцэтгэхэд ажиллуулахаар тооцсон хугацаа зэрэг нь Хавсралт В-д тодорхой тусгагдсан. Хавсралт В-д нэр, албан тушаалаар нь жагсааж бичсэн голлох боловсон хүчин болон туслан гүйцэтгэгчдийг захиалагч үүгээр зөвшөөрч байна.

4.2 Боловсон хүчинийг солих/халах

- (a) Захиалагч өөрөөр зөвшөөрснөөс бусад тохиолдолд Голлох боловсон хүчин/ажилтанд өөрчлөлт хийгдэхгүй. Хэрэв Үйлчилгээ үзүүлэгчээс хамаарахгүй шалтгаанаар голлох боловсон хүчин/ажилтныг солих шаардлагатай гарвал Үйлчилгээ үзүүлэгч нь түүнтэй ур чадвараараа дүйцэхүйц эсхүл түүнээс илүү чадвартай боловсон хүчинийг оронд нь ажиллуулахаар санал болгоно.
- (b) Хэрэв Үйлчилгээ үзүүлэгчийн боловсон хүчин нь (i) эрүүгийн гэмт хэрэгт холбогдсон болох нь тогтоогдсон, (ii) гэрээний дагуу гүйцэтгэж буй ажил үүргээ хангалтгүй биелүүлсэн зэргийг захиалагч мэдсэн бол эдгээр үндэслэлээр тухайн ажилтныг захиалагчийн хүлээн зөвшөөрөхүйц чадвар, туршлагатай өөр ажилтнаар солиулах хүсэлтийг Үйлчилгээ үзүүлэгчид бичгээр гаргана.
- (v) Боловсон хүчинийг халах эсхүл солих үйл явдалтай холбоотой гарах аливаа нэмэлт зардлыг Үйлчилгээ үзүүлэгч захиалагчаас нэхэмжлэх эрхгүй.

5. Захиалагчийн эрх үүрэг

5.1 Туслалцаа болон Хөнгөлөлт

Үйлчилгээ үзүүлэгчид ГТН-д заасан хөнгөлөлт, туслалцааг үзүүлэхэд шаардлагатай бүх талын арга хэмжээг захиалагч авч хэрэгжүүлнэ.

5.2 Гэрээний хуульд өөрчлөлт орох

Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш гэрээний хууль тогтоомжид татвар хураамжтай холбоотой өөрчлөлт орсны улмаас Үйлчилгээ үзүүлэгчийн санал болгосон үйлчилгээний өртөг нэмэгдэж, эсхүл буурч өөрчлөгдөхөөр бол талууд хоорондоо хэлэлцээр хийж

гэрээний дагуу хийх нөхөн төлбөрийн хэмжээг уг өөрчлөлтийн хэмжээгээр нэмэгдүүлэх эсхүл бууруулах ба энэ тохиолдолд 6.2 (а) эсхүл (б)-д заасан гэрээний үнэд харгалзах тохируулгыг хийнэ. Захиалагч нь Үйлчилгээ үзүүлэгчийг Хавсралт Е-д дурдсан тоног төхөөрөмж болон үйлчилгээгээр хангах үүрэгтэй.

5.3 Үйлчилгээ ба техник хэрэгсэл

6.1 Нийт-үнэд үндэслэсэн үйлчилгээний төлбөр

6.2 Гэрээний үнэ

6.3 Нэмэлт үйлчилгээний төлбөр хийх

6.4 Төлбөр хийх нөхцөл ба болзлууд

6.5 Хугацаа хоцорсон төлбөрт төлөх хүү

6.6 Үнийн тохируулга

6. Үйлчилгээ үзүүлэгчид хийгдэх төлбөр

Үйлчилгээ үзүүлэгчид төлөх төлбөр нь гэрээний үнээс хэтрэхгүй бөгөөд энэ нь үйлчилгээ үзүүлэгч болон түүний бүх туслан гүйцэтгэгчээс Хавсралт А-д тодорхойлсон ажил үйлчилгээг гүйцэтгэхэд гарах бүх зардлыг багтаасан тогтмол нийт үнэ байна. 5.2 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд зөвхөн 2.4 ба 6.3 зүйлүүдийн дагуу нэмэлт төлбөр хийхийг талууд зөвшөөрсөн тохиолдолд гэрээний үнэ 6.2 дугаар зүйлд заасан хэмжээнээс хэтэрч болно.

- (а) Дотоод валютаар төлөгдөх гэрээний үнийг ГТН-д тусгана.
- (б) Гадаад валютаар төлөгдөх гэрээний үнийг ГТН-д тусгана.

6.3.1 2.4 дүгээр зүйлийн дагуу тохиролцсон бол уг нэмэлт үйлчилгээнд төлөх төлбөрийг тодорхойлоход Хавсралт Г ба Д-д заасан нийт үнийн задаргааг ашиглана.

Төлбөрийг ГТН-д тодорхойлсон төлбөрийн хуваарийн дагуу Үйлчилгээ үзүүлэгчид төлнө. ГТН-д өөрөөр заагаагүй бол эхний төлбөр нь уг төлбөрийн хэмжээтэй дүйцэхүйц мөнгөн дүнтэй, ГТН-д заасан хугацааны туршид хүчин төгөлдөр байх банкны баталгааг захиалагч хүлээж авсаны үндсэн дээр хийгдэнэ. Бусад аливаа төлбөр нь ГТН-д заасан тухайн төлбөрийг төлөх нөхцөл хангагдсан үед Үйлчилгээ үзүүлэгчээс төлбөрийн нийт хэмжээг тодорхойлсон төлбөрийн нэхэмжлэлийг захиалагчид ирүүлсний дараа хийгдэнэ.

Хэрэв захиалагч ГТН-д заасан төлбөр хийх хугацаанаас (15) ба түүнээс дээш хоногоор хоцроож төлбөр хийх тохиолдолд хугацаа хоцроосон өдөр бүрт ГТН-д заасан хувь хэмжээгээр тооцож Үйлчилгээ үзүүлэгчид хүү төлнө.

Зөвхөн гэрээний тусгай нөхцөлд үнэ тохируулахаар заасан нөхцөлд үндсэн зардлын үнийн хэлбэлзлийг тусгах зорилгоор үнийн тохируулга хийнэ. Ингэхдээ төлбөрийн мэдэгдлийн нийт дүнгээс урьдчилгаа төлбөрийг хассан дүнгийн төлбөр хийх валют тус бүрийн үнийн дүнг холбогдох үнийн тохируулгын үзүүлэлт (P_c)-ийг ашиглан дараах байдлаар тохируулна.

$$P_c = A_c + B_c \frac{Lmc}{Loc} + C_c \frac{Imc}{Loc}$$

Энд:

P_c гэрээний “c” валютаар төлөгдөх хэсэгт хийх үнийн тохируулгын үзүүлэлт;

Ac, Bc and Cc гэрээний тусгай нөхцөлд заасан итгэлцүүрүүд: гэрээний үнийн “с” валютаар төлөгдөх хэсгийн (A_c)-тохируулга хийгдэхгүй, (B_c)-ажиллах хүчтэй холбоотой тохируулга хийгдэх болон (C_c)-бусад орцын тохируулга хийгдэх хувийн жинг үзүүлсэн итгэлцүүр;

I_{M_c} – нэхэмжилж буй сарын эцсийн хоногт зонхилж буй “с” валютын хөдөлмөрийн индекс;

I_{O_c} – тендерийг нээхээс 28 өдрийн өмнө зонхилж буй “с” валютын хөдөлмөрийн индекс.

I_{M_c} – нэхэмжилж буй сарын эцсийн хоногт зонхилж буй “с” валютын бусад орцод хамаарах индекс;

I_{O_c} – тендерийг нээхээс 28 өдрийн өмнө зонхилж буй “с” валютын бусад орцод хамаарах индекс.

Хэрэв үнийн тохируулгын үзүүлэлт нь тухайн зардлын индексийн валютаас өөр валютаар төлөгдөх төлбөрт хамаарах бол Zo/Zn гэсэн залруулах хүчин зүйлийг ашиглаж томьёог залруулна. Zo нь тендер нээхээс 28 хоногийн өмнө тухайн төлбөр хийх валютын нэг нэгж нь дотоод валютын хэдэн нэгжтэй тэнцүү байгааг харуулна. Харин Zn одоогийн индексийн өдрийн тэр валютын нэгжийн тоог харуулна.

6.6.2 Хэрэв индексийн дүн нь түүнийг тооцоонд ашигласнаас хойш өөрчлөгдсөн бол тооцоог залруулж, дараагийн төлбөрийн мэдэгдэлд энэ дагуу тохируулга хийнэ. Индексийн дүн нь үнийн хэлбэлзлийн улмаас гарсан зардлын бүх өөрчлөлтийг тусгасан гэж үзнэ.

6.7.1 Шаардлагатай бол зөвхөн захиалагчийн урьдчилан бичгээр гаргасан зааварчилгааны дагуу бага хэмжээний нэмэлт ажил, үйлчилгээний төлбөрийг төлөхөд Үйлчилгээ үзүүлэгчийн тендерт дурдсан ажил-өдрийн нэгж үнийг ашиглана.

6.7.2 Үйлчилгээ үзүүлэгч ажил-өдрөөр тооцогдон төлөгдөх бүх ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн талаар захиалагчийн баталсан маягтын дагуу тэмдэглэл хөтөлнө. Бөглөсөн маягтыг ажил үйлчилгээг гүйцэтгэснээс хойш 2 хоногийн дотор багтааж захиалагчаар, эсхүл түүнийг төлөөлөх эрх бүхий этгээдээр батлуулна.

6.7.3 Захиалагч 6.7.2-т дурдсаны дагуу батлуулсан ажил-өдрийн маягтыг үндэслэн ажил-өдрийн төлбөрийг үйлчилгээ үзүүлэгчид төлнө.

7. Чанарын хяналт

- 7.1 Зөрчил гологдол илрүүлэх** Захиалагч Үйлчилгээ үзүүлэгчийн ажил, үйлчилгээний гүйцэтгэлийг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Ийнхүү шалгах нь Үйлчилгээ үзүүлэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Захиалагч зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажил, үйлчилгээнд зөрчил, гологдол хайх, уг үйлчилгээний далд хэсгийг нээх, аль нэг үйлчилгээний туршилт хийхийг Үйлчилгээ үзүүлэгчээс шаардах эрхтэй. Чанарын баталгаат хугацааг ГТН-д тодорхойлсны дагуу байна.
- 7.2 Зөрчил, гологдол арилгах, Дутуу гүйцэтгэлд торгууль ногдуулах**
- (a) Захиалагч гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг Үйлчилгээ үзүүлэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.
 - (b) Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр Үйлчилгээ үзүүлэгч уг зөрчил, гологдлыг захиалагчийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.
 - (c) Хэрэв үйлчилгээ үзүүлэгч нь Захиалагчийн мэдэгдэлд заасан хугацаанд гаргасан алдаа дутагдлыг арилгаагүй бол Захиалагч зөрчлийг арилгахад гарах зардлыг үнэлж 3.8 дугаар зүйлд зааснаар тооцож дутуу гүйцэтгэсэн ажлын торгуулийг ногдуулах бөгөөд Үйлчилгээ үзүүлэгч уг торгуулийг захиалагчид төлөх үүрэгтэй.

8. Маргааныг шийдвэрлэх

- 8.1 Маргааныг шийдвэрлэх** Талууд гэрээтэй холбоотой гарах аливаа маргааныг харилцан зөвшилцэж эв зүйгээр шийдвэрлэхийг хичээнэ. Хэрэв талууд тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргаж шийдвэрлүүлнэ.

ХАВСРАЛТ

Хавсралт А—Үйлчилгээний тодорхойлолт

БАГЦ – 1

Эмнэлгийн тусгай хог хаягдал зайлцуулах, устгах үйлчилгээ:

Эрүүл мэндийн байгууллагын оношлогоо, эмчилгээ, үйлчилгээний явцад үүсэх хүн, амьтны бие, эрхтэн, эд, хэсэг, бичил биетийн өсгөвөр, цус, бусад шингэн, ялгадас, эм, эмийн бүтээгдэхүүн, био бэлдмэл, зүү, тариур, хурц үзүүртэй, иртэй багаж хэрэгсэл, химиин болон цацраг идэвхт бодис зэрэг хог хаягдлыг цуглуулан, эмнэлгээс гадагши тээвэрлэх, халдвартгүйтгэх, зайлцуулах, устгах үйл ажиллагаа.

БАГЦ – 2

Эмнэлгийн ердийн хог хаягдал зайлцуулах, устгах үйлчилгээ:

Эрүүл мэндийн байгууллагын албан тасалгаа, үйлчилгээний өрөө, агуулах, хонгил, орчны эдэлбэр газарт үүсэх ахуйн / сав баглаа боодол, хоол хүнс, жимсний хальс гэх мэт/ ба дахин боловсруулах / Шил, цаас, цаасан хайрцаг, хөнгөн цагаан, хаягдал төмөр болон төрөл бүрийн хуванцар гэх мэт/ хог хаягдлыг цуглуулан, эмнэлгээс гадагши тээвэрлэх, халдвартгүйтгэх, зайлцуулах, устгах үйл ажиллагаа.

БАГЦ – 3

Хортон мэрэгчдийн устгах үйлчилгээ:

Гадна болон дотор орчны бүхий л эд зүйлс, хөрсөн байгаа өвчин үүсгэгч, ахуйн хортон шавьж, бусад үе хөлтөн, хортон мэрэгдийн хор хөнөөлийн талаар мэдээлэл өгөх, сурталчилах, тэдгээрийг илрүүлэн тодорхойлох, устгах, халдвартгүйжүүлэх үйл ажиллагаа.

БАГЦ – 4

Ариутгал, халдвартгүйтгэлийн бараа худалдан авах:

Хавсралт Б—Төлбөрийн хуваарь ба Тайлан

- “Тайланг ирүүлэх шаардлагагүй”**

Хавсралт В—Голлох боловсон хүчин ба туслан гүйцэтгэгчид

Багц - 4

- Бүтээгдэхүүнийг ачиж, буулгах, зөөх ажилтантай байх;**
- Хэрэгжүүлэх хангалттай ажиллах хүчиний нөөцтэй болохыг нотлох 3-аас доошигүй ажилтны анкет ажилтан тус бүрээр ирүүлэх;**
- Ажилтан тус бурийн нийгмийн даатгалын дэвтэрийн нүүр болон татвар төлөлтийн хуулбар, тухайн ажилтанг томилсон тэмдэглэлийн хуулбар; /нийгмийн даатгалын хэлтэсийн тодорхойлолт болон НД-8 маягтын дагуу 3 сарын маягт ирүүлэх/**

Хавсралт Д—Гэрээний үнийн Дотоод валютаар хийгдэх хэсгийн задаргаа

- Үйлчилгээний хөлс “**төгрөг**”-өөр хийгдэнэ.

Хавсралт Е—Захиалагчийн үзүүлэх үйлчилгээ болон техник хэрэгсэл

- *Захиалагч нь эмнэлгийн болон ахуйн хог хаягдлыг нэг цэгт төвлөрүүлжс ачиж устгахад бэлтгэсэн байх;*
- *Захиалагч нь эмнэлгийн болон ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан зориулалтын нөхцөлөөр хог хаягдлыг бэлтгэсэн, уут, хайрицаанд хийж битүүмжилсэн байх;*
- *Хортон шавьж, мэрэгч устгах, мөөгөнцөр, хөрсний ариутгал хийх газар, талбайг тогтоож, хийлгэх газарт хүргэх хөтөч гарган үйлчилгээг авах;*
- *СЭМҮТ-ийн Ерөнхий захирлын баталсан ажлын цагийн хуваарийн дагуу ажил үйлчилгээ, бүтээгдэхүүнийг хүлээн авах албан тушаалтаныг томилон ажиллуулах;*

БҮЛЭГ VII. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮР ДҮНГИЙН ТОДОРХОЙЛОЛТ БА ЗУРАГ

БАГЦ -4

Барааны техникийн тодорхойлолтын хураангуй.

Нийлүүлэгдэх бараа болон холбогдох үйлчилгээ нь дор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна.

<i>Нэр төрлийн дугаар</i>	<i>Бараа болон холбогдох үйлчилгээний нэр</i>	<i>Техникийн тодорхойлолт болон стандарт</i>
1.	<i>Хүрүү үзүүртэй, иртэй хог хаягдал хийх аюулгүйн хайрцааг</i>	<p>Эрүүл мэндийн сайдын 2011 оны 05 сарын 03-ны өдрийн 158 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт-д заасан шаардлагад нийцэхүйц</p> <p>Өнгө: Шар</p> <p>Материал: Хатуу цаасан</p> <p>Таних тэмдэг: Биоаюулгүйн таних тэмдэг бүхий хайрцаагын гадна талд байрлуулна</p>  <p>Хэмжээ: Гэрээнд заасан хэмжээтэй</p> <p>Тусгай шаардлага: <u>“ЭНЭ ТҮВШНЭЭС ХЭТРҮҮЛЭН ДҮҮРГЭХИЙГ ХОРИГЛОНО”</u> гэсэн анхааруулгыг хайрцаагын гадна талын 2/3 хэсэгт байрлуулсан, Ус нэвчдэггүй, цоорч гэмтдэггүй, таглаатай, зориулалтын хатуу цаасан аюулгүйн хайрцааг, хүрүү үзүүртэй, иртэй хог хаягдал хийх зориулалт бүхий байх;</p>
2.	<i>Гарын хатуу саван</i>	<p>MNS 0241:1998 ерөнхий шаардлага хангасан, дээд бүлгийн ангилалынх байх;</p> <p>Өнгө: Савангийн нэр төрлөөс хамаарч янз бүрийн байх /цагаан, ягаан, цайвар шаргал гэх мэт/;</p> <p>Материал: Тосны хүчлийн хэмжээ нь хатаасны дараа 76 хувиас доошигүй, натрийн чөлөөт шүлтийн хэмжээ нь 0,08% /хувь/-с дээшигүй, савангас ялгарсан тосны хүчлийн царцах температур 35-42, хөөсрөлтийн анхны</p>

		<p>эзэлхүүний хэмжээ 400 мл-ээс доошигүй, давсны хэмжээ 0,5% /хувь/-с ихгүй байх;</p> <p>Хэмжээ: 90 гр</p> <p>Тавигдах тусгай шаардлага: Барихад хатуу, нягт байх, элдэв өнгийн судал толбогүй, нэр төрөлд зохицсон ургамлын анхилуун тод үнэртэй, гадны хольцгүй, хүний биед сөрөг үр дагавар өгөхгүй, эрүүл ахуйн шаардлага хангасан, бактерын эсрэг агууламжтай байх;</p>
3.	Вок	<p>Өнгө: Нэр төрлөөс хамаарч янз бүрийн байх /цагаан, ягаан, цайвар шаргал гэх мэт/;</p> <p>Материал: Цайруулагч, энзим, толбо арилгагч, ус зөөлөгч, өнгө сэргээгч, бактер устгагч агуулсан, анион идэвхтэй бодис 5-15% /хувь/-н хооронд, ионы бус гадаргуугийн идэвхт бодис 0,5% /хувь/-с ихгүй, зориулалтын нийлэг уутан савлагаатай байх;</p> <p>Хэмжээ: 1000 гр</p> <p>Тавигдах тусгай шаардлага: Нэр төрөлд зохицсон ургамлын анхилуун тод үнэртэй, гадны хольцгүй, хүний биед сөрөг үр дагавар өгөхгүй, эрүүл ахуйн шаардлага хангасан байх;</p>
4.	Цайруулагч	<p>Ахуйн болон үйлчилгээний цайруулагч, халдвартгүйжүүлэх бодис, нян болон ариутгах үйлчилгээтэй байх;</p> <p>Өнгө: Бүтээгдэхүүний нэр төрлөөс хамаарч янз бүрийн байх /цагаан, өнгөгүй/ гэх мэт;</p> <p>Найллага: Шингэн, анион идэвхит бодис /surfactant/-ын агуулга нь 5% /хувь/-с ихгүй байх, зориулалтын хуванцар савлагаатай байх;</p> <p>Хэмжээ: 1000 мл</p> <p>Тавигдах тусгай шаардлага: Нэр төрөлд зохицсон ургамлын анхилуун тод үнэртэй, гадны хольцгүй, хүний биед сөрөг үр дагавар өгөхгүй, эрүүл ахуйн шаардлага хангасан байх;</p>
5.	Аяга таваг угаагч шингэн	<p>Олон улсын стандартыг хангасан, бүх төрлийн аяга, шаазан, шилэн эдлэл, сав суулга, угаалтуур угааж цэвэрлэх зориулалттай байх;</p>

		<p>Өнгө: Бүтээгдэхүүний нэр төрлөөс хамаарч янз бүрийн байх /цагаан, ягаан, цайвар шаргал гэх мэт/;</p> <p>Найрлага: Шингэн, анионы гадаргуугийн идэвхт бодис 5-15% /хувь/, ионы бус гадаргуугийн идэвхт бодис 5% /хувь/-с ихгүй, аммоны сульфат, дээд спиртууд, хлор, бисульфат, өнгө, үнэр оруулагч бодисуудыг агуулсан, зориулалтын хуванцар савлагаатай байх;</p> <p>Хэмжээ: 500 мл</p> <p>Тавигдах тусгай шаардлага: Нэр төрөлд зохицсон ургамлын анхилуун тод үнэртэй, гадны хольцгүй, фосфор, триклосан агуулаагүй, хүний биед сөрөг үр дагавар өгөхгүй, эрүүл ахуйн шаардлага хангасан байх;</p>
6.	Эдийн саван	<p>MNS 0241:1998 ерөнхий шаардлага, MNS 398:86 стандартыг хангасан байх;</p> <p>Өнгө: Цагаан өнгөтэй байх;</p> <p>Материал: 60-72 хувийн тослогтой, тосны хүчлийн хэмжээ 60% /хувь/-с доошигүй, ажс ахуйн савангийн чанарын тоо 120 ± 1, натрийн шүлтийн хэмжээ 0,2% /хувь/-с доошигүй, савангас ялгарсан тосны хүчлийн царцах температур 35-45, хөөсрөлтийн анхны эзэлхүүний хэмжээ 300 мл-ээс доошигүй байх;</p> <p>Хэмжээ: 195-200 гр байх;</p> <p>Тусгай шаардлага: Барихад хатуу, нягт байх, элдэв өнгийн судал толбогүй, хүний биед сөрөг үр дагавар өгөхгүй, эрүүл ахуйн шаардлага хангасан, үнэр багатай байх;</p>
7.	Резин бээлий	<p>Гар хамгаалах хэрэгсэл нь MNS 5622:2006 стандартад заагдсан тэмдэглэгээ болон MNS 4931:2000 стандартын шаардлагыг хангасан байх;</p> <p>Өнгө: Улаан, шар;</p> <p>Материал: Материалын найрлагадаа неопрон агуулсан, сайн чанарын резин байх;</p> <p>Хэмжээ: Урт нь 305 мм-ээс дээш, 1-3 мм зузаан байх, резмер бүрийн сонголттой байх;</p> <p>Тусгай шаардлага: Бээлий болон түүний баглаа боодол дээр тэдгээрийн зориулалт,</p>

		<p>ашиглалтын зааврыг бичсэн, зориулалтаар нь ашиглахад гарын арьсанд сөрөг нөлөөлөл, цочрол узүүлэхгүй, хөнгөн, гар, хурууны хөдөлгөөнд саад дарамт учруулахгүйгээр хийгдсэн, эрүүл ахуй, халдварт хамгааллын шаардлагад нийцсэн, эдэлгээ даах чадвар өндөр, зүсэлт тэсвэрлэх чадвар сайн, давтан хэрэглэх боломж маш сайтай, хатгалт тэсвэрлэх чадвартай, химиин бодисоос хамгаалах чадвар сайтай, цэвэрлэгээ хийхэд зориулагдсан зөвлөн чанарын резин байх, үнэргүй байх;</p>
8.	<i>Ердийн хог хаягдлын уут</i>	<p>Эрүүл мэндийн сайдын 2011 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 158 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт-д заасан шаардлагад нийцэхүйц;</p> <p>Өнгө: Хар</p> <p>Материал: Нийлэг</p> <p>Таних тэмдэг: Тавих шаардлагагүй;</p> <p>Хэмжээ: урт 90* өргөн 60 /см/, 5 микронос багагүй зузаантай байх;</p> <p>Тусгай шаардлага: Шил, цаас, цаасан хайрцаг, хөнгөн цагаан, хаягдал төмөр болон төрөл бүрийн хуванцар зэрэг дахин боловсруулах хог хаягдал хийх, амархан цоорч гэмтэхгүй, шингэн нэвчдээгүй, бөх бат байх;</p>
9.	<i>Ердийн хог хаягдлын уут</i>	<p>Эрүүл мэндийн сайдын 2011 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 158 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт-д заасан шаардлагад нийцэхүйц;</p> <p>Өнгө: Хар</p> <p>Материал: Нийлэг</p> <p>Таних тэмдэг: Тавих шаардлагагүй;</p> <p>Хэмжээ: урт 60 * өргөн 50 /см/, 5 микронос багагүй зузаантай байх;</p> <p>Тусгай шаардлага: Шил, цаас, цаасан хайрцаг, хөнгөн цагаан, хаягдал төмөр болон төрөл бүрийн хуванцар зэрэг дахин боловсруулах хог хаягдал хийх, амархан цоорч гэмтэхгүй, шингэн нэвчдээгүй, бөх бат байх;</p>

		<p>Эрүүл мэндийн сайдын 2011 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 158 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт-д заасан шаардлагад нийцэхүйц;</p> <p>Өнгө: Шар</p> <p>Материал: Нийлэг</p> <p>Таних тэмдэг: Биоаюулгүй таних тэмдэг бүхий гурвалжин таних тэмдгийг уутны гадна талд заавал байрлуулна;</p>  <p>Хэмжээ: урт 45 * өргөн 30 /см/, 5 микронос багагүй зузаантай байх;</p> <p>Тусгай шаардлага: Эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх явцад үүсэх халдвартын эрсдэл бүхий биеийн өтгөн, шингэн ялгадас, цус, цэр, шүлс, г.м.-ээр бохирлогдсон зүйлс; арьс, салстыг арчиж цэвэрлэх, эмчилгээ үйлчилгээнд хэрэглэсэн цаас, самбай, хөвөн, даавуу г.м. боолтын материал; нэг удаагийн хуванцар багаж хэрэгсэл, гуурс, толь, бээлий, систем, малгай, амны хаалт, хуучирсан цагаан хэрэглэл болон бусад халдвартай хог хаягдал хийх зориулалт бүхий амархан цоорч гэмтэхгүй, шингэн нэвчдэггүй, бат бөх байх;</p>
	<p>10.</p> <p>Халдвартай хог хаягдын уут</p>	<p>Эрүүл мэндийн сайдын 2011 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 158 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт-д заасан шаардлагад нийцэхүйц;</p> <p>Өнгө: Улаан</p> <p>Материал: Нийлэг</p> <p>Таних тэмдэг: Биоаюулгүй таних тэмдэг бүхий гурвалжин таних тэмдгийг уутны гадна талд заавал байрлуулна;</p> 
	<p>11.</p> <p>Халдвартай хог хаягдын уут</p>	<p>Эрүүл мэндийн сайдын 2011 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 158 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт-д заасан шаардлагад нийцэхүйц;</p> <p>Өнгө: Улаан</p> <p>Материал: Нийлэг</p> <p>Таних тэмдэг: Биоаюулгүй таних тэмдэг бүхий гурвалжин таних тэмдгийг уутны гадна талд заавал байрлуулна;</p> 

		<p>Хэмжээ: урт 45 * өргөн 30 /см/, 5 микронос багагүй зузаантай байх</p> <p>Тусгай шаардлага: Олон улсын эрүүл мэндийн дүрэм (ОУЭМД)-ээр зохицуулагддаг болон байгалийн голомтот халдварт өвчинүүд, сурьеэ, бэлгийн замын халдварт өвчинүүдийн үед болон лабораториос үүсэх хог хаягдлууд (эд эсийн өсгөвөр дэхь эмгэг төрөгч агуулсан амьд үүсгэгч, тэжээлт орчин, тэдгээрийг хэрэглэхэд ашиглагдаж буй багаж хэрэгсэл) халдварын зэрэг өндөртэй хог хаягдал агуулах зориулалт бүхий амархан цоорч гэмтэхгүй, шингэн нэвчдэггүй, бат бөх байх;</p>
		<p>Эрүүл мэндийн сайдын 2011 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 158 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт-д заасан шаардлагад нийцэхүйц;</p> <p>Өнгө: Хүрэн</p> <p>Материал: Нийлэг</p> <p>Таних тэмдэг: Биоаюулгүйн таних тэмдэг бүхий гурвалжин таних тэмдгийг уутны гадна талд заавал байрлуулна</p>
12.	Эм болон химийн бодисын хог хаягдлын уут	 <p>Хэмжээ: урт 45 * өргөн 30 /см/, 5 микронос багагүй зузаантай байх;</p> <p>Тусгай шаардлага: Хугацаа дууссан, хэрэглэхийг хориглосон, хагарч гэмтсэн, бохирдсон эм, биобэлдмэл, вакцин, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм, бодис агуулсан сав, туншил, хайрцаг гэх мэт хог хаягдал эмийн хог хаягдал, оношлогоо эмчилгээ, шинжилгээ, судалгаа, цэвэрлэгээ, үйлчилгээ, ариутгал, халдвартгүйтгэлийн үйл ажиллагааны явцад үүссэн хатуу, шингэн, хийн байдалтай лабораторийн хаягдал (урвалж оношлуур, химийн бодисын хаягдал г.м.), ариутгалын бодис, уусгагч, рентген зургийн хальс бэхжүүлэх, боловсруулах уусмал, формальдегид, этилен оксид, хугацаа дууссан химийн бодисууд гэх мэт химийн бодисын хог хаягдал агуулах зориулалт бүхий амархан</p>

		<i>цоорч гэмтэхгүй, шингэн нэвчдэггүй, бат бөх байх;</i>
13.	<i>Xүнсний уут</i>	<p>Хүнсний уйлдвэрлэл үйлчилгээнд зориулагдсан хүнсний уут нь хүнсний бүтээгдэхүүнд сөрөг нөлөө узуулэхгүй, хоргүй, бат бөх, хүнсийг бохирдолтоос бүрэн хамгаалж чадах, химиин гадны нөлөөнөөс хамгаалах, 8-10 кг-ийн даацтай, бүтээгдэхүүн хэсэгчлэн хадгалахад зориулагдсан, стандарт, эрүүл ахуйн шаардлага хангасан, бариултай байх;</p> <p>Өнгө: Өнгөгүй Материал: Нийлэг Таних тэмдэг: Тавих шаардлагагүй; Хэмжээ: урт 50* өргөн 45 /см/, 5 микроноос багагүй зузаантай байх;</p>
14.	<i>Бусад уут</i>	<p>Эмнэлэг үйлчилгээнд ашиглах, амархан цоорч гэмтэхгүй, шингэн нэвчдэггүй, стандарт, эрүүл ахуйн шаардлага хангасан бариулгүй байх;</p> <p>Өнгө: Өнгөгүй Материал: Нийлэг Таних тэмдэг: Тавих шаардлагагүй; Хэмжээ: урт 30* өргөн 20 /см/, 3,5 микроноос багагүй зузаантай байх;</p>

БҮЛЭГ IX. БАТАЛГААНЫ МАЯГТ

БАТАЛГААНЫ МАЯГТ

Баталгааны маягтыг бэлтгэх санамж

Тендерийн, гүйцэтгэлийн болон урьдчилгаа төлбөрийн баталгааны зөвшөөрөгдөх маягтуудыг хавсаргав. Тендерт оролцогчид тендерийн хамт тендерийн баталгааг энэ бүлэгт заасан маягтаар ирүүлнэ.

Харин гүйцэтгэлийн болон урьдчилгаа төлбөрийн баталгааг шалгарсан тендерт оролцогч энэ бүлэгт заасан маягтаар ирүүлнэ. Урьдчилгаа төлбөрийн баталгааг ирүүлэх шаардлагагүй бол урьдчилгаа төлбөрийн баталгааны маягтыг тендерийн баримт бичигт хавсаргахгүй.

Тендерт оролцогчийн ирүүлэх тендерийн, гүйцэтгэлийн болон урьдчилгаа төлбөрийн баталгаа нь энэ бүлэгт заасан маягтын дагуу байх ба агуулгын хувьд өөрчлөлт ороогүй боловч өөр хэлбэр /формат/-тэй ирүүлсэн баталгааг захиалагч зөвшөөрнө.

Хавсралт А.Маягт: Тендерийн баталгаа (Банкны баталгаа)

(БАНКНЫ БАТЛАН ДААЛТ)

[Захиалагч байгууллагын нэр]

[Тендерт оролцогчийн нэр] (Цаашид “Тендерт оролцогч” гэх) нь [Тендер шалгаруулалтын нэр]-ийн барилгын ажлыг гүйцэтгэхээр тендер (цаашид “Тендер” гэх) санал болгосонтой ХОЛБОГДУУЛАН,

Энэхүү баталгаагаар [Банкны нэр] (цаашид “Банк” гэх) нь [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх)-ийн өмнө нийт [мөнгөн дүн]-ийн төлбөр хийх үүрэг хүлээж батлан даалт гаргаж байна.

Төлбөр хийх үүрэг нь дор дурдсан нөхцөлд үүснэ. Үүнд:

- (1) тендерийг нээсний дараа тендерийн маягтад заасан тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө тендерт оролцогч өөрийн тендерийг буцааж авсан;
- (2) захиалагч тендер хүчинтэй байх хугацаанд багтаж гэрээ байгуулах эрх олгосон үед тендерт оролцогч:
 - (а) Тендерт оролцогчдод өгөх заavarчилгааны дагуу гэрээг байгуулаагүй бол;
 - (б) Тендерт оролцогчдод өгөх заavarчилгааны дагуу гүйцэтгэлийн баталгааг ирүүлээгүй бол;
- (в) Тендерт оролцогчдод өгөх заavarчилгааны дагуу хийгдсэн тендерийн үнийн алдааны залруулгыг хүлээн зөвшөөрөөгүй бол.

Энд тодорхойлогдсон нөхцөлүүдийн аль нэг нь үүссэнийг дурдаж дээр зааснаас хэтрэхгүй мөнгөн дүнтэй тэнцэх төлбөр хийх тухай захиалагчийн анхны шаардлагыг бичгээр хүлээн авсан даруй банк нь төлбөрийг үл маргалдах журмаар хийнэ.

Энэхүү баталгаа нь тендер хүчинтэй байх хугацаанаас хойш 28 хоногийн дотор хүчинтэй. Захиалагч баталгаатай холбогдсон аливаа шаардлагыг энэ хугацаанд багтаж банкинд мэдэгдэх ёстой.

Та бүхнийг хүндэтгэсэн,

Банкны эрх бүхий албан тушаалтны гарын үсэг _____

Албан тушаал, нэр _____

Банкны тамга

Огноо: _____

Хаяг: _____